

САНХҮҮГИЙН
САЛБАРЫН ТОЙМ

2016

ӨМНӨХ ҮГ



Банкнаас бусад санхүүгийн салбарт СЗХ–ноос 2016 оны хоёрдугаар хагаст баримталсан гол бодлогыг “эрсдэлээс сэргийлэх” хэмээн тодорхойлж болно. Эдийн засгийн идэвхжил саарч, чанаргүй зээлийн хэмжээ улам бүр өссөөр байгаа нь санхүүгийн салбарын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж буйд бид дүгнэлт хийж мөчлөг сөрсөн бодлого барьж ажиллалаа. Үүний үр дүнд салбарын оролцогчдын чадавх тодорхой дүнгээр сайжирч, ерөнхий үзүүлэлтүүд өсөлттэй гарлаа.

Үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 1,474.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 16.8 хувиар, даатгалын салбарын нийт хөрөнгө 208.4 тэрбум төгрөг болж 20.3 хувиар, банк бус санхүүгийн байгууллагын салбарынх 787.2 тэрбум төгрөгт хүрч 26.3 хувиар, ХЗХ–дын нийт хөрөнгийн дүн 113.1 тэрбум төгрөг болж 15.8 хувиар тус тус өслөө. Эдгээр өсөлтүүдэд гадаад, дотоод олон хүчин зүйлс нөлөөлсөн нь мэдээж. Ялангуяа, олон улсын зах зээл дээр эрдэс түүхий эдийн үнэ сэргэсэн, эдийн засгийн өсөлтөд итгэх иргэдийн итгэл, хүлээлт өсөн нэмэгдсэн, салбарын дотоод өрсөлдөөн сайжирсан зэргийг нэрлэх учиртай. Хамгийн чухал нь төрийн зохицуулалт тогтвортой болж, банкнаас бусад санхүүгийн салбарыг хөгжүүлэх дунд болон урт хугацааны бодлогоо тодорхой болгож чадсан маань голлон нөлөөлсөн гэж үзэж байна.

Хэдийгээр мэдэгдэхүйц өсөлт гарсан ч гэлээ үнэт цаас болон хөрөнгийн зах зээл, бичил санхүүгийн ба даатгалын салбарт тааруу үзүүлэлтүүд, шийдэх шаардлагатай асуудлууд байсаар байна. Хөрөнгийн болон даатгалын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний

нэр төрөл, төлбөр хураамж, нөхөн төлбөрийн хэмжээ тэр бүр үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад явцав нийцэхгүй байгааг сайжруулах, үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээл өнөө хэр бий болоогүй байгааг үүсгэн хөгжүүлэх, банкнаас бусад санхүүгийн салбарт зээлийн хүүг зохистой хэмжээнд хүртэл бууруулах шаардлагатай байна. Үүний тулд хууль, эрх зүйн болон зохицуулалт, хяналтын орчныг боловсронгуй болгож, арилжаа, төлбөр тооцоо, гүйлгээний дэд бүтцийг сайжруулж, нэгдсэн бодлогод зангидах явдал юу юунаас илүү чухлаар тавигдаж байна.

Банкнаас бусад салбарт хөрөнгө, санхүүг удирдах, захиран зарцуулах үйл ажиллагааг улам бүр хариуцлагатай, сахилга баттай болгож, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, хадгаламж болон даатгуулагчдын эрх ашгийг хангах, хүртэх өгөөжийг өсгөх, салбарын эрсдэлийг бууруулах нь Санхүүгийн зохицуулах хорооны нэн тэргүүний үүрэг гэж үзэж байна. Энэ үүргээ бид санхүүгийн зах зээлийг улам идэвхжүүлж, засаглалыг сайжруулан, шударга, чөлөөт өрсөлдөөн бүхий хүртээмжтэй үйлчилгээ, боловсронгуй зохицуулалт бий болгож байж биелүүлнэ.

Учир нь хөгжлийн нөхцөл хангагдсан зах зээлээс л оролцогч, үйлчлүүлэгчдийн хэн хэн нь зүй ёсны өгөөж хүртэж чаддаг билээ.

СОДНОМДАРЖААГИЙН ДАВААСҮРЭН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

2016.1.15

Санхүүгийн зах зээлийн форумыг зохион байгуулав.

2016.03.23

Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулахаар СЗХ-ны 2016 оны 94 дүгээр тогтоолоор зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг эдийн засаг болон үнэт цаасны компаниудын үйл ажиллагааны нөхцөл байдалтай уялдуулан нэмэгдүүлэв.

2016.06.15

“Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 355 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлэх хугацааг 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгалаа.

Даатгалын компаниуд Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу тайлангаа хөтөлдөг болж СЗХ-ны 2016 оны 49 дүгээр тогтоолоор “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”, “Даатгалын компанид мөрдөх дансны жагсаалт”-ыг шинэчлэн баталлаа.

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-тэй хамтран гишүүн орнуудын хооронд Жижиг, дунд үйлдвэрийн санхүүгийн Ажлын хэсэг (SME Finance working group)-ийн 6 дугаар чуулга уулзалтыг зохион байгууллаа.

Дэлхийн банкинд Монгол Улсын санхүүгийн салбарын өнөөгийн байдал, УИХ, ЗГ-аас дэвшүүлж байгаа хөтөлбөр, СЗХ-ны бодлого, зохицуулалтын төлөв, чиг хандлагыг танилцуулан, Олон салбарыг хамарсан техник туслалцааны 2 дахь шатны төслийг хэрэгжүүлэх чиглэлүүдийг хэлэлцэв.

2016.03.04

2016.05.24

2016.10.04



2016.10.18

ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2.5 тэрбум төгрөгт хүргэн шинэчлэн тогтоолоо.



2016.10.28

Монгол Улсын хадгаламж, зээлийн хоршооны салбарын 20 жилийн ойг тохиолдуулан Монголын хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбоотой хамтран “Хөгжлийн төлөө хамтдаа” үндэсний хоёрдугаар форумыг зохион байгууллаа.



2016.12.16

Орон сууцны ипотекийн зээлдэгчийг хүртээмжтэй, оновчтой хэлбэрээр даатгалд хамруулах санал боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулав.



2016.10.26

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-тай хамтран “Нэг зорилго-Нэг шийдэл” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.



2016.10.30

ХЗХ-дын үйл ажиллагаанд зориулсан нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг Азийн хөгжлийн банктай хамтран нэвтрүүлэв.

Эх сурвалж: www.frc.mn

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	1
ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭ.....	2
I. 2016 ОНЫ ХУРААНГУЙ ТОЙМ	
1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	12
1.1.1 Үнэт цаасны зах зээл.....	12
1.1.2 ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл.....	12
1.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	12
1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	13
1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	13
II. БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
2.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	16
2.1.1 Үнэт цаасны зах зээл.....	16
2.1.2 ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл.....	19
2.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	20
2.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	26
2.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	28
III. ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ	
3.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	32
3.1.1 Үнэт цаасны зах зээл.....	32
3.1.2 ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл.....	35
3.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	36
3.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	38
3.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	40
IV. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ	
4.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	44
4.1.1 Үнэт цаасны зах зээл.....	44
4.1.2 ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл.....	46
4.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	47
4.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	48
4.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	49



ИНФОГРАФИК	50
V. АШИГТ АЖИЛЛАГАА	
5.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	54
5.1.1 Үнэт цаасны зах зээл.....	54
5.1.2 ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл.....	56
5.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	56
5.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	58
5.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	62
VI. ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	
6.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	66
6.2 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	68
VII. БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН	
7.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	72
7.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	73
7.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	73
7.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	74
ХЭРЭГЛЭГЧДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮЛЭЭЛТ.....	75
ББСБ–ЫН ХНХ–ИЙГ ТОГТООСОН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА	78
ХАВСРАЛТ	79
МЭДЭЭЛЛИЙН СУРВАЛЖ.....	83

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид.....	21
Хүснэгт 2: Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хураамжийн орлогын өсөлтийн хувь /2016–2015/.....	23
Хүснэгт 3: Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо.....	33
Хүснэгт 4: Хувьцаат компанийн хувьцааны бүтэц.....	34
Хүснэгт 5: Зохицуулалттай этгээдийн тоо.....	34
Хүснэгт 6: Үнэт цаасны арилжааны үзүүлэлт.....	44
Хүснэгт 7: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөгөөр/.....	45
Хүснэгт 8: 2016 оны ХАА–н биржийн арилжааны хэмжээ, дүн.....	46
Хүснэгт 9: Нийт хөрөнгө /тэрбум төгрөгөөр/.....	54
Хүснэгт 10: Нийт орлого /тэрбум төгрөгөөр/.....	55
Хүснэгт 11: ХЗХ–дын ашгийн хэмжээ /бүлгээр/.....	59
Хүснэгт 12: ХНХ–өөр ангилсан байдал.....	63
Хүснэгт 13: ХЗХ–дын хадгаламжийн үйл ажиллагаа /тэрбум төгрөгөөр/.....	69
Хүснэгт 14: ХНХ–ийн олон улсын харьцуулалт.....	78

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Хөрөнгийн зах зээлийн бүтэц.....	16
Зураг 2: Зах зээлийн үнэлгээ ба ДНБ–ний харьцуулалт.....	17
Зураг 3: Зах зээлийн үнэлгээ ба хөрвөх чадвар.....	18
Зураг 4: ТОП–20 индекс.....	18
Зураг 5: ХАА–н биржийн арилжаа.....	19
Зураг 6: МАРИХ индекс.....	20
Зураг 7: Даатгалын зах зээлийн бүтэц.....	21
Зураг 8: Ердийн даатгалын компаниудын зах зээлд эзлэх хувь.....	22
Зураг 9: Даатгалын гүнзгийрэлтийн түвшин.....	24
Зураг 10: Даатгалын салбарын нийт хөрөнгө.....	24
Зураг 11: Хураамжийн орлого.....	25
Зураг 12: Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж.....	25
Зураг 13: Нөөц сангийн хэмжээ, өсөлт.....	26
Зураг 14: Банк санхүүгийн байгууллагын бүтэц.....	26
Зураг 15: Нийт хөрөнгө ба ДНБ–ний харьцаа.....	27
Зураг 16: ББСБ ба харилцагчдын тоо.....	27
Зураг 17: ХЗХ–ны бүтэц.....	28
Зураг 18: ХЗХ–д ба гишүүдийн тоо /мянгаар/.....	28
Зураг 19: Нийт хөрөнгө ба ДНБ–ний өөрчлөлт.....	29
Зураг 20: “ҮЦТХТ” ХХК–д нээгдсэн дансны тоо.....	32

Зураг 21: Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь	33
Зураг 22: Хөдөө орон нутгууд дахь брокеруудын байршил	35
Зураг 23: ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн арилжаа /бүтээгдэхүүнээр/	36
Зураг 24: Даатгалын нягтрал /төгрөгөөр/	36
Зураг 25: Даатгалын компани болон зуучлагчдын салбаруудын байршил/аймгаар/	37
Зураг 26: Даатгалын компани болон зуучлагчдын салбаруудын байршил /дүүргээр/	37
Зураг 27: ББСБ-уудын хүртээмж /бүс нутгаар/	38
Зураг 28: ББСБ-уудын хүртээмж /дүүргүүдээр/	38
Зураг 29: Бүс нутгууд дахь зээлийн тархалт	39
Зураг 30: Дүүргүүд дэх зээлийн тархалт	39
Зураг 31: ХЗХ-дын тоо /бүс нутгаар/	40
Зураг 32: ХЗХ-дын хүртээмж /байршлаар/	40
Зураг 33: ХЗХ-дын тоо, өсөлтийн хувь	41
Зураг 34: Хувьцааны арилжаа /тэрбум төгрөгөөр/	44
Зураг 35: Нийт зуучлагчдын даатгалын хураамжийн орлого /бүтцээр/	47
Зураг 36: Даатгалын төлөөлөгчөөр дамжиж орсон хураамжийн орлого	48
Зураг 37: ББСБ-уудын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон орлого	48
Зураг 38: ХЗХ-дын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон орлого	49
Зураг 39: ХЗХ-дын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс гарсан зардал	49
Зураг 40: ҮЦК-уудын тоо /брокер, дилер/	55
Зураг 41: Цэвэр ашиг	56
Зураг 42: Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж	57
Зураг 43: Зардлын харьцаа, хохирол нөхөлтийн харьцаа, хосолсон харьцаа	57
Зураг 44: Хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж	58
Зураг 45: Нийт хөрөнгийн өгөөж /ХНХ-ийн ангиллаар/	59
Зураг 46: Өөрийн хөрөнгийн өгөөж /ХНХ-ийн ангиллаар/	60
Зураг 47: Өгөөжийн дундаж түвшин	60
Зураг 48: Ахиуц ашиг болон хөрөнгийн эргэц /ББСБ-ын тоогоор/	61
Зураг 49: Хөшүүрэг	61
Зураг 50: ХЗХ-дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөг/	62
Зураг 51: Хугацаа хэтэрсэн ба чанаргүй зээлийн хувь (салбараар)	66
Зураг 52: Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хувь (ББСБ тус бүрээр)	67
Зураг 53: Зээлийн эрсдэлийн сан	67
Зураг 54: ХЗХ-дын чанаргүй зээл /тэрбум төгрөгөөр/	68
Зураг 55: ХЗХ-дын зээлийн чанар	69
Зураг 56: ХИИ ба ДНБ	76
Зураг 57: ХИИ /бүсээр/	76

ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ 1: Үнэт цаасны зах зээлийн байдал.....	19
Шигтгээ 2: Цахим сүлжээний даатгал ба эрсдэл	23
Шигтгээ 3: Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн хөгжлийн бодлого.....	56
Шигтгээ 4: Сүүдрийн банк ба бичил санхүүгийн салбар.....	68

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1: Хөрөнгийн зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/.....	79
Хавсралт 2: Даатгалын зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/.....	80
Хавсралт 3: ББСБ–уудын статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/.....	81
Хавсралт 4: ХЗХ–дын статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/.....	82

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТТ	Арилжааны төлбөр тооцоо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНХАУ	Бүгт Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
МББСБХ	Монголын Банк бус санхүүгийн байгууллаудын холбоо
МИК	Монголын ипотекийн корпораци
МҮЦАЭХ	Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо
МХБ	Монголын хөрөнгийн бирж
МХЗХҮХ	Монголын Хадгаламж, зээлийн хоршоодын Үндэсний холбоо
ОССК	Орон сууцны санхүүжилтийн корпораци
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮЦТТХТ	Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХАА	Хөдөө аж ахуй
ХИИ	Хэрэглэгчийн итгэлийн индекс
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
ХК	Хувьцаат компани
ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо
МАРІХ	Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн индекс





2016 ОНЫ
ХУРААНГУЙ ТОЙМ

2016 ОНЫ ХУРААНГУЙ ТОЙМ

Банкнаас бусад санхүүгийн зах зээл 2016 онд 2.6 их наяд төгрөгт хүрч, дунджаар 20 хувиар өссөн нь төрийн дэмжлэг, бодлого зохицуулалтын орчинд гарсан өөрчлөлт голчлон нөлөөллөө. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030 хөтөлбөр” болон 71 дүгээр тогтоолоор “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг батлаж үүний хүрээнд банкнаас бусад санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар олон тулгуурт санхүүгийн зах зээлийн тогтолцоонд хүрэх зорилгыг дэвшүүлээд байна. Иймд цаашид банкнаас бусад санхүүгийн зах зээлийг өргөжүүлэхэд ЗГ–аас сангийн бодлогоор, санхүүгийн зах зээлийн бодлого тодорхойлогчдоос мөнгөний болон зохицуулалтын бодлогоор дамжуулан анхаарч ажиллах нөхцөл бүрдлээ.

1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

1.1.1 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Хөрөнгийн зах зээл дээр 2016 онд Засгийн газрын үнэт цаас, хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа явагдаж, хувьцааны зах зээлийн үнэлгээ 1,474.2 тэрбум төгрөгт хүрснээр өмнөх оны мөн үеэс 16.8 хувиар өслөө. Зах зээлийн үнэлгээнд үнэт цаасаа олон нийтэд арилжсан хоёр компанийг нэмж оруулан тооцсоноор үнэлгээ өсөхөд голлох нөлөөг үзүүлжээ.

Тайлант хугацаанд ТОП–20 индекс өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар, MSE ALL индекс 3.9 хувиар буурсан үзүүлэлттэй гарав. 2016 онд “Монголын хөрөнгийн бирж” ХК–иар дамжуулан 348.7 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн. Үүний 85.9 хувийг ЗГҮЦ–ны арилжаа эзлэх бөгөөд анхдагч зах зээлийн арилжаагаар 3.1 сая ширхэгийг 280.5 тэрбум төгрөгөөр харин хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 196.4 мянган ширхэгийг 19.2 тэрбум төгрөгөөр арилжжээ. Зах зээлийн нийт арилжааны 14.1 хувийг эзлэх хувьцааны 244 удаагийн арилжаагаар 126 компанийн 93.7 сая ширхэг үнэт цаасыг 49.0 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Тайлант хугацаанд тусгай зориулалтын 4 компанийн 501.2 сая ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус тус бүртгээд байна.

1.1.2 ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөдөө аж ахуйн биржээр дамжин нийт 8 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагддагаас тайлант хугацаанд 5 төрөл нь арилжаалагдаж, 2016 онд 463.0 тэрбум төгрөгийн

181 удаагийн арилжаа хийгджээ. Арилжаалагдсан бараа, түүхий эдийн хэмжээг өмнөх онтой харьцуулахад 29.1 тэрбум төгрөг буюу 6.7 хувийн өсөлттэй гарсан. Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн МАРИХ индекс 2016 оны тавдугаар сарын 03–ны өдөр хамгийн их буюу 601.2 мянган төгрөг байсан бол 2015 оны гуравдугаар сарын 30–ны өдөр хамгийн бага буюу 470.6 мянган төгрөг байв. Тайлант хугацаанд СЗХ–ны тусгай зөвшөөрөлтэй хөдөө аж ахуйн 37 брокер үйл ажиллагаагаа явуулсан байна.

1.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Монгол Улсын даатгалын зах зээл дэх хөрөнгө оруулалтын хэмжээ өсөлттэй гарсан нь нийт хөрөнгийн хэмжээг өсгөв. Түүнчлэн гадаадын давхар даатгалын компанид төлсөн хураамжийн болон үйл ажиллагааны зардал буурсан нь татварын дараах цэвэр ашгийн хэмжээг нэмэгдүүллээ. Улмаар даатгалын салбар дахь цэвэр ашгийн хэмжээ 64 хувиар өссөн үзүүлэлттэй гарав.

Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2015 онтой харьцуулахад 20.3 хувиар өсөж, 208.4 тэрбум төгрөгт хүрлээ. Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.9 хувиар өссөн. Энэхүү өсөлтийн 48,7 хувийг нийт хөрөнгө оруулалтын өсөлт голчлон бүрдүүлэв. Тэр дундаа үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 3 дахин өссөн үзүүлэлттэй гарсан.

Харин урт хугацааны даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 7.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5 хувиар буурав. Нийт хөрөнгийн дийлэнх хувь буюу 55.7 хувийг хөрөнгө оруулалтын дүн эзэлж байгаа бөгөөд үүнээс хадгаламж, хадгаламжийн сертификат 58.8 хувь, үнэт цаас 41.2 хувийг тус тус бүрдүүллээ. Тайлант хугацаанд хадгаламж, хадгаламжийн

сертификат 1.3 тэрбум төгрөгөөр буюу 34.7 хувиар буурсан нь нийт хөрөнгийн бууралтад голчлон нөлөөлөв.

Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.5 хувиар өсөв. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хөрөнгө оруулалтын дүн өмнөх оноос 4 дахин өссөн бөгөөд нийт хөрөнгийн 94.1 хувийг эзэлж байна. Хадгаламж, хадгаламжийн сертификат хэлбэрээр байршуулсан хөрөнгө оруулалтын дүн өмнөх оноос 2 дахин өсөж 18.0 тэрбум төгрөгт хүрсэн бол үнэт цаас хэлбэрээр нийт 15.0 тэрбум төгрөгийг байршуулжээ.

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 111.7 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласан ба давхар даатгалын хураамжийн зардалд 33.3 хувийг, нийт нөхөн төлбөрийн зардал 29.9 хувийг, үйл ажиллагааны зардалд 32.0 хувийг зарцуулсан. Ердийн даатгалын компаниудын татварын дараах цэвэр ашиг өмнөх оноос 83.9 хувиар өссөн бөгөөд үүнд үйл ажиллагааны зардлын 54.1 хувь, давхар даатгалын хураамжийн 11.3 хувийн бууралт голчлон нөлөөлөв.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд 1.2 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оноос 23.2 хувиар буурсан үзүүлэлт байв. Нийт хураамжийн орлогод эзлэх давхар даатгал, нөхөн төлбөр, үйл ажиллагааны зардлын хувь хэмжээ өссөн боловч зардлын хэмжээг тооцож үзвэл 8.8 хувиар буурчээ. Хэдий зардлын хэмжээ буурсан боловч хураамжийн орлогын хэмжээ багассан нь татварын дараах цэвэр ашгийн хэмжээг 24.9 хувиар унахад хүргэв.

Давхар даатгалын компани нийт 2.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.7 хувиар өссөн байна. Давхар даатгалын хураамжийн нийт орлого 1.6 тэрбум төгрөг болж 2015 оны жилийн эцсээс 1.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэв. Харин нийт нөхөн төлбөрийн зардал 4.6 сая төгрөг буюу давхар даатгалын нийт хураамжийн орлогын 0.3 хувийг эзэлж байна.

1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ-уудын тоо 2013 оноос эхлэн огцом нэмэгдэж байгаатай холбоотой СЗХ-ноос тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийг үе шаттай нэмэгдүүлэх шийдвэр гаргаснаар нийт хөрөнгө 26.3 хувиар өсөж 787.2 тэрбум төгрөгт хүрэв. ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 15 хувиар нэмэгдсэнээр 518 хуулийн этгээд үйл ажиллагаа эрхэлж байна. Гэсэн хэдий ч энэ онд ББСБ-уудаар үйлчлүүлэгчдийн тоо буурч, нийт зээлийн үлдэгдэл 478.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд чанаргүй зээлийн хэмжээ 12.4 хувь болж өмнөх оны мөн үеэс 2.6 нэгжээр

нэмэгдсэн. Харин хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үеэс 0.1 нэгжээр буурснаар 5.6 хувьд хүрлээ.

ББСБ-ууд тайлант хугацаанд 193.4 тэрбум төгрөгийн орлоготой ажиллаж, 59.0 тэрбум төгрөгийн цэвэр ашгийг хуримтлуулсан. ББСБ-ууд 8 төрлийн бүтээгдэхүүнээс орлого бүрдүүлснээс зээлийн хүүгийн орлого 133.7 тэрбум төгрөг буюу 94.0 хувийг эзэлж байна.

Хүртээмжтэй байдлаараа ББСБ-уудын тоо 10,000 хүнд ногдох тоогоороо Улаанбаатар хотод 4, хөдөө орон нутагт 0.6 байгаа бол 100 аж ахуйн нэгжид Улаанбаатар хотод 1.2, хөдөө орон нутагт 0.1 байна.

ББСБ-ын салбарын хөрөнгийн өгөөж 8.4 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.2 нэгжээр өссөн бол өөрийн хөрөнгийн өгөөж 11.8 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.5 нэгжээр буурлаа.

1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 280 ХЗХ-оос 65.7 хувь буюу 184 нь Улаанбаатар хотод, 34.3 хувь буюу 96 нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

Тайлант хугацаанд ХЗХ-дын тоо өмнөх оноос 10.7 хувиар, гишүүдийн тоо 18.0 хувиар, нийт хөрөнгийн хэмжээ 15.8 хувиар тус тус өссөн байна. Нийт хөрөнгө болон зээлийн банкны салбарт эзлэх хувь өсөж байгаа нь “Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр”-т 123 ХЗХ хамрагдсантай холбоотой бөгөөд банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 15.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 7,037 гишүүнээр өссөн ба үүнээс Улаанбаатар хотын гишүүд 16.6 хувиар, орон нутгийн гишүүд 13.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

“Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн хөтөлбөр”-ийн 118 ХЗХ-оос 54 ХЗХ нь 0.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан нь салбарын нийт алдагдлын 5.5 хувьтай тэнцэж байна. Мөн 4 ХЗХ ашиг болон алдагдалгүй, 60 ХЗХ 0.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Тус ХЗХ-дын нийт хүүгийн орлого 1.8 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардал 1.9 тэрбум төгрөг, тайлант үеийн алдагдал нь 0.09 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.4 хувиар буюу 0.05 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Цаашид ХЗХ-дын хөгжлийг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулах үүднээс Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг шинэчлэх шаардлага үүсээд байна.



Mar

Apr

May

Jun

Jul

Aug

Sep

Oct



БАНКНААС БУСАД
САНХҮҮГИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


2.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2.1.1 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Хөрөнгийн зах зээлийн бүтэц: Хөрөнгийн зах зээл дээр нийт 2 төрлийн санхүүгийн хэрэгсэл болох хувьцаа болон бонд арилжаалагддаг. Харин зах зээлийн бүтцийн байгууллагуудын хувьд хөрөнгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны арилжаа тооцоо 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх

3 банк, мөнгөн төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх 5 банк, хөрөнгө оруулалтын менежментийн 13 компани, хөрөнгө оруулалтын 4 сан, брокер, дилерийн 62 компани, андеррайтерийн /давхардсан тоогоор/ 25, хөрөнгө оруулалтын зөвлөхийн 16 компани /давхардсан тоогоор/ тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 1: Хөрөнгийн зах зээлийн бүтэц



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөрөнгийн зах зээлийн хөгжлийг зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, үнэт цаасны арилжааны ДНБ-д эзлэх хувь, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хувьцааны индекс гэсэн үндсэн үзүүлэлтүүдээр илэрхийлж авч үздэг бөгөөд тухайн улсын хувьд дээрх хөгжлийн үзүүлэлтүүд ямар

түвшинд хүрснээс хамаарч гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэх, хөрөнгө оруулалтын урсгал бий болох, улмаар бүс нутгийн хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд байгаа эсэхийг тодорхойлдог.

Зах зээлийн үнэлгээ: Үнэт цаасны зах зээлийн багтаамж,


түүний эдийн засагт үзүүлэх нөлөөг дунд болон урт хугацаанд дэмжигч гол үзүүлэлт нь үнэт цаасны зах зээлийн үнэлгээ бөгөөд үүний өсөлт, бууралт нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн түвшинг, улмаар эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөө үзүүлж байгааг илэрхийлэгч үндсэн индикатор болдог.

2016 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 1,474.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 211.7 тэрбум төгрөг буюу 16.8 хувиар өссөн. 2015 онд “МИК холдинг” ХК-ийн 1.6 сая ширхэг хувьцааг 19.5 тэрбум төгрөгөөр, 2016 онд “Монгол шуудан” ХК-ийн үнэт цаасны 34 хувь буюу 33.9 сая ширхэг хувьцааг 6.3 тэрбум төгрөгөөр тус тус олон нийтэд анх удаа санал болгон арилжаалж, улмаар 2016 оны нийт зах зээлийн үнэлгээнд дээрх хоёр компанийг оруулж тооцсон нь зах зээлийн үнэлгээ өсөхөд голлох нөлөөг үзүүлсэн.

Мөн 2016 оны 2 дугаар хагасаас олон улсын зах зээл дээр түүхий эдийн үнэ ханш сэргэх төлөв бий болсон нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг болон манай улсын үнэт цаасны зах зээлийн үнэлгээний дийлэнх хувийг илэрхийлдэг ТОП-20 индексэд багтдаг нэр бүхий 6 компанийн хувьцааны ханш 21.5 хувиар өссөн нь зах зээлийн үнэлгээнд нөлөөлжээ.

2016 оны эцсийн байдлаар ЗЗҮ-г нэрлэсэн ДНБ-тэй харьцуулсан үзүүлэлт өмнөх оны мөн үеийнхээс 0.8 хувиар, ЗЗҮ-д хувьцааны арилжааны үнийн дүнг харьцуулсан хөрвөх чадварын үзүүлэлт 0.92 хувиар өссөн дүнтэй гарсан. Хөрвөх чадварын түвшин өсөхөд “Монгол шуудан” ХК-ийн 33.9 сая ширхэг хувьцааг 6.3 тэрбум төгрөгөөр хувьцааны анхдагч зах зээлд арилжсан болон багцын арилжаагаар нэр бүхий 11 компанийн 41.9 сая ширхэг хувьцааг 34.1 тэрбум төгрөгөөр арилжсан нь голлох нөлөөг тус тус үзүүлсэн бөгөөд багцын арилжаа нийт хувьцааны арилжааны 69.6 хувийг бүрдүүлсэн.

Зураг 2: Зах зээлийн үнэлгээ ба ДНБ-ний харьцуулалт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, ҮСХ

Тайлант хугацаанд нийт зах зээлийн үнэлгээний 87.7 хувийг 30 компани бүрдүүлсэн бөгөөд эдгээр компаниудын дийлэнх нь уул уурхай, аж үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нь уул уурхайн салбарын өсөлт, бууралттай холбоотойгоор дотоодын үнэт цаасны зах зээлийн үнэлгээнд шууд нөлөөлөв.

Манай улсын хувьд хувьцааны хөрвөх чадварын түвшин бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад доогуур

түвшинд байгаа ба үүнд хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцаа хэт төвлөрсөн, компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал хангалтгүй, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл цөөн, олон нийтийн хөрөнгө оруулалт, хувьцааны талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг зэрэг хүчин зүйлс гол нөлөөг үзүүлж байна.

Зураг 3: Зах зээлийн үнэлгээ ба хөрвөх чадвар




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны зах зээлийн индексүүд: Тайлант хугацаанд ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4 хувиар буурч, 12,456.1 нэгжид хүрсэн бөгөөд индексийн дээд утга 12,939.5, доод утга 10,485.7, дундаж утга 11,550.1 нэгж байна.

MSE ALL индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 хувиар буурч, 861.2 нэгжид хүрчээ. Тус индексийн дээд үзүүлэлт 894.9 нэгж, доод үзүүлэлт 761.2 нэгж, дундаж үзүүлэлт 827.2 нэгжтэй гарлаа.

Зураг 4: ТОП-20 индекс



Эх сурвалж: "Монголын хөрөнгийн бирж" ХК

2.1.2 ХАА-Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

ХАА-н биржийн хөгжил: Монгол Улсын Их Хурлаас 2011 онд баталсан Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗГ-ын 30 дугаар тогтоол, Төрийн өмчийн СЗХ-ны 45 дугаар тогтоол гарч “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийг үүсгэн байгуулж төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд болон гүйцэтгэх удирдлагыг томилсон. ХАА-н бирж нь свот болон үүсмэл гэрээний арилжааг зохион байгуулах, төлбөр тооцоог гүйцэтгэх, биржийн арилжаанд оролцогчдыг сургах, мэргэшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Хөдөө аж ахуйн бирж нь анх 2013 оны дөрөвдүгээр сарын 05-ны өдрөөс хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалж эхэлсэн ба 4 жилийн хугацаанд нийт 1,852.0 тэрбум төгрөгийн 669 удаагийн арилжаа явуулжээ.

ХАА-н биржээр дамжин 2013 онд 403.7 тэрбум, 2014 онд 554.1 тэрбум, 2015 онд 431.7 тэрбум, 2016 онд 463 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

2014 онд төгрөгийн ханш суларснаар биржийн түүхий эдийн үнэ өсөж, арилжааны хэмжээ 2013 оноос 37 хувиар нэмэгдсэн бол 2015 онд биржийн арилжааны голлох хувийг эзэлдэг ноолуурын гадаад зах зээл дэх үнийн уналтаас үүдэн биржийн арилжааны хэмжээ 22 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан. Харин 2016 онд арилжсан бараа, түүхий эдийн хэмжээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 29.1 тэрбум төгрөг буюу 6.7 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.


ШИГТГЭЭ 1:

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН БАЙДАЛ

Монгол Улсын эдийн засаг 2011 онд уул уурхайн салбарын өсөлттэй холбоотойгоор 17.5 хувиар нэмэгдэж, бүс нутаг болоод олон улсын хэмжээнд эдийн засгийн өсөлтийн хурдаар тэргүүлэх болсон. Үүнтэй холбоотойгоор Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, ТОП-20 индексийг бүрдүүлэгч уул уурхайн салбарын компаниудын хувьцааны ханш огцом нэмэгдэх болсон ба үүнийг дагаад манай улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид болон мэргэжлийн зуучлагч брокеруудын тоо ихээр нэмэгдсэн байна. Гэвч 2012 оноос хойших хугацаанд олон улсын санхүүгийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ ханш унасан, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан, эдийн засгийн өсөлт удааширсан зэрэг шалтгаануудын улмаас манай хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадварын үзүүлэлтүүд буурсаар байна.

Хэдийгээр хөрөнгийн зах зээлийн хөгжлийн суурь нөхцөл болох үнэт цаасны зах зээлийн хууль, эрх зүйн орчин сүүлийн жилүүдэд сайжирч, хяналт, зохицуулалтын оновчтой тогтолцоо бүрдэх боломж бий болж байгаа хэдий ч, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжил сул, тэр дундаа төлбөр, тооцоо, арилжааны систем болон мэргэжлийн зуучлагч байгууллагуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт хомс, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадвар доогуур, үр ашигтай хяналт, зохицуулалтын механизм бүрдээгүй зэрэг нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд сөрөг нөлөөг үзүүлж байна.

Зураг 5: ХАА-н биржийн арилжаа



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтээс шалтгаалан 1 болон 4 дүгээр улирлуудад арилжааны хэмжээ буурдаг ба 2 болон 3 дугаар улирлуудад свот арилжаа идэвхждэг.

2016 онд өдөрт дунджаар 2.6 тэрбум төгрөгийн арилжааг

181 өдөр хийсэн ба 2016 оны 5 дугаар сард хамгийн их буюу 100.3 тэрбум төгрөг, 2015 оны 02 дугаар сард хамгийн бага буюу 1.4 сая төгрөгийн арилжаа хийсэн байна.

ХАА-Н БИРЖИЙН ИНДЕКС

Зураг 6: МАРИХ индекс



Эх сурвалж: Хөдөө аж ахуйн бирж

Хөдөө аж ахуйн бирж нь 2015 оноос эхлэн индекс тооцоолон мэдээллэж эхэлсэн. МАРИХ нь “Mongolian Agricultural Price Index” буюу “Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн индекс” гэсэн нэрийн товчлол бөгөөд арилжаалагдаж байгаа барааны үнийг тусгай загвараар жигнэж тооцоолсон үнэ юм.

МАРИХ индекс 2016 оны 5 дугаар сарын 03-ны өдөр хамгийн их буюу 601,188.0 нэгж байсан бол 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хамгийн бага буюу 470,589.0 нэгж байжээ.

2.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын зах зээлийн бүтэц: Тайлант хугацаанд нийт 229 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, актуарч, аудитын компани СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байна. 2016 оны жилийн эцсийн байдлаар дээр дурдсан мэргэжлийн оролцогчдын тоо 9-өөр өсжээ.

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын зах зээлд өнөөгийн байдлаар ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 1 компани, давхар даатгалын 1 компани бүртгэгджээ. Харин мэргэжлийн оролцогчдын хувьд 40 даатгалын зуучлагч үүнээс 9 давхар даатгалын зуучлагч, 31 даатгалын хохирол үнэлэгч, 3091 даатгалын төлөөлөгчид тус тус СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Түүнчлэн даатгалын компаниуд, мэргэжлийн оролцогчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилго бүхий, ашгийн төлөө бус холбоод СЗХ-той санамж

бичгийн хүрээнд хамтран ажилладаг. Эдгээр холбоодыг дурдвал Албан журмын даатгагчдын холбоо, Монголын даатгагчдын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын хохирол үнэлэгчдийн холбоо зэрэг юм.

Даатгалын компаниуд болон мэргэжлийн оролцогчдын санхүүгийн үйл ажиллагаа болон нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтлөлт хийж буй эсэхэд хяналт тавих, баталгаажуулах үүднээс аудитын компаниудад СЗХ-ноос эрх олгодог. Одоогоор нийт 42 аудитын компани болон 126 аудиторт тус эрхийг олгоод байна.

Хүснэгт 1: Даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид


Он	Ердийн даатгал	Урт хугацааны даатгал	Давхар даатгал	Даатгалын зуучлагч	Хохирол үнэлэгч	Актуарч	Аудитын компани	Аудитор	Нийт
2007	15	-	-	2	-	-	-	-	17
2008	15	1	-	4	-	9	-	-	29
2009	17	1	-	5	2	10	-	-	35
2010	16	1	-	9	6	12	-	-	44
2011	16	1	-	8	9	13	-	-	47
2012	17	1	-	17	9	18	16	43	121
2013	16	1	-	20	14	15	22	69	157
2014	16	1	-	30	20	15	30	84	196
2015	15	1	1	37	27	15	40	124	260
2016	15	1	1	40	31	15	42	126	271

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 онд нэр бүхий нэг даатгалын компанийн ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь хэмжээ өнгөрсөн оноос 1.7 хувиар буурч 18.3 хувьд хүрсэн боловч зах зээлд хамгийн өндөр хувийг эзэлсэн хэвээр байна. Нэр бүхий 4 даатгалын компани нийт хөрөнгийн хэмжээгээрээ тус тус ердийн даатгалын зах зээлийн 7 хувиас 10.4 хувийг эзэлж байна.

2015 онд дээр дурдсан нэр бүхий даатгагчид ердийн даатгалын зах зээлийн 51.5 хувийг эзэлж байсан бол уг үзүүлэлт энэ оны жилийн эцэст 1.7 хувиар өсөж, 53.1 хувь болов. Бусад ердийн даатгалын компаниудын хувьд зах зээлд эзлэх хувь хэмжээ ижил түвшинд буюу 2.6–аас 6.7 хувийг, дунджаар 4.7 хувийг эзэлж байна.

Зураг 8: Ердийн даатгалын компаниудын зах зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын зах зээлийн хөгжил: Дэлхийн эдийн засгийн өсөлт сул, инфляцийн түвшин доогуур, санхүүгийн зах зээлийн хэлбэлзэл өндөр, зээлийн хүү доогуур түвшинд тогтсон зэрэг макро эдийн засгийн болон санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал нь даатгалын зах зээлд нөлөө үзүүлэв. Санхүүгийн хямралаас хойш хураамжийн орлогын өсөлт хямралын өмнөх түвшингээс харьцангуй доогуур байна.

Олон улсын хэмжээнд ердийн даатгалын хураамжийн орлогын өсөлт өнгөрсөн оноос удаашрав¹. Өнгөрсөн жил бодит хураамжийн орлогын өсөлт 3.0 хувь байсан бол тайлант жил 2.4 хувийн өсөлттэй байв. Хөгжингүй орнуудад эдийн засгийн өсөлт удааширч, арилжааны даатгалын бүтээгдэхүүний үнэ уян хатан тогтож байсантай уялдаж, нийт хураамжийн орлогын өсөлт 2.5 хувиас 1.7 хувь болж буурав. Харин хөгжиж буй орнуудын хувьд хураамжийн орлогын өсөлт өнгөрсөн оноос бага хэмжээгээр сайжирч, 5.3 хувьд хүрсэн боловч уг үзүүлэлт 2000 оноос 2014 онуудын дундаж өсөлт болох 8 хувиас доогуур түвшинд байна². Хөгжиж буй орнуудын нийт хураамжийн орлого нэмэгдэхэд ердийн даатгалын 60

орчим хувийг³ эзлэх авто тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүний өсөлт томоохон хувь нэмэр оруулжээ.

2016 онд дэлхийн урт хугацааны даатгалын хураамжийн орлого 2015 оны 5 хувийн өсөлтөөс дээшилж, 5.4 хувьд хүрэв. Хөгжингүй орнуудын урт хугацаат даатгалын хураамжийн орлогын өсөлт 2015 онд 3.4 хувь байсан бол 2016 онд 2.0 хувь болж буурлаа. Олон улсын хэмжээнд урт хугацааны даатгалын салбарын өсөлтөд хөгжиж буй орнуудын, тэр дундаа Азийн хөгжиж буй орнуудын зах зээлийн өсөлт гол нөлөө үзүүлсэн. Хөгжиж буй орнуудын урт хугацаат даатгалын хураамжийн орлогын өсөлт өмнөх оноос 6.9 нэгжээр өсөж 20.1 хувьд хүрэв⁴.

1 Swiss Re (2016a): Global insurance review 2016 and outlook 2017/18, November
2 IAIS: Global Insurance Market Report 2016

3 Swiss Re (2016b): The future of motor insurance: How car connectivity and ADAS are impacting the market, March
4 IAIS: Global Insurance Market Report 2016

Хүснэгт 2: Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хураамжийн орлогын өсөлтийн хувь /2016–2015/

Үзүүлэлт	Ердийн даатгалын хураамжийн орлогын өсөлт	Урт хугацааны даатгалын хураамжийн орлогын өсөлт	Нийт хураамжийн орлогын өсөлт
Дэлхий	2.4% ↓	5.4% ↑	*
Хөгжингүй орнууд	1.7% ↓	2.0% ↓	*
Хөгжиж буй орнууд	5.3% ↑	20.1% ↑	*
Монгол Улс	0.5% ↓	23.2% ↓	0.2%

Эх сурвалж: GIMAR 2016, IAIS

Харин 2016 оны жилийн эцэст манай орны ердийн болон урт хугацааны даатгалын хураамжийн орлого буурсан байна. Өмнөх оны мөн үеэс ердийн даатгалын

хураамжийн орлого 0.5 хувиар, урт хугацааны даатгалын хураамжийн орлого 23.2 хувиар буурчээ.

ШИГТГЭЭ 2:

ЦАХИМ СҮЛЖЭЭНИЙ ДААТГАЛ БА ЭРСДЭЛ

Хэрэглэгчид санхүүгийн болон эрүүл мэндийн мэдээллээ өргөн хүрээнд цахим хэлбэрээр хадгалах болсон нь цахим сүлжээний эрсдэлийн хамгаалалт хөгжихөд чухал нөлөө үзүүлэх болов. Хүмүүс цахим харилцаанаас илүү хамааралтай болж, бизнесийн байгууллагууд хэрэглэгчдийн нарийн мэдээлэл цуглуулж, мэдээллийн сан үүсгэх болсон нь эсрэгээрээ нийгэмд хор уршиг учруулах боломжийг нээлттэй болгож байна.

Цахим сүлжээний мэдээллийн аюулгүй байдал алдагдах эрсдэл нэмэгдэж байгаатай холбоотой даатгалын бүтээгдэхүүний хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлэх болов. Даатгалын салбарт цахим сүлжээний даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр нэвтрүүлснээр уг халдлагын эсрэг хариу арга хэмжээ авч, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой. Энэхүү шинэ төрлийн бүтээгдэхүүн нь хувийн болоод бизнесийн орчинд үүсэж буй цахим сүлжээний эрсдэлийг даатгана. Цахим сүлжээний даатгал нь жижиг цар хүрээг хамарч байгаа хэдий ч цаг үеэ дагаад хурдацтай хөгжихөөр байна. 2014 онд АНУ-ын даатгалын зах зээлд энэ төрлийн даатгалын бизнес 2.0 тэрбум орчим ам.долларын орлоготой ажиллаж байсан бөгөөд тус зах зээл нь нийт ердийн даатгалын 0.3 хувийг эзэлжээ. АНУ-ын цахим сүлжээний даатгалын зах зээл өдгөө энэ төрлийн даатгалын бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд тэргүүлэх байр суурьтай байна. Европын Холбооноос компаниудад хэрэглэгчдийн мэдээллийг хамгаалалтад авах үүрэг ногдуулсан Мэдээлэл хамгааллын тухай хууль, дүрмийг шинэчилсэн нь Европын цахим сүлжээний даатгалын зах зээл эрчимтэй хөгжихөд түлхэц өгөв. Дэлхийн дөрвөн том аудитын компанийн нэг PwC-ээс гаргасан судалгаанд дэлхийн цахим сүлжээний даатгал нь 2018 онд 5.0 тэрбум ам.доллараар, 2020 онд 7.5 тэрбум ам.доллараар өсөх боломжтой хэмээн дурджээ.

Энэ төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд даатгагч нарт тулгарч буй гол асуудал нь эрсдэлийг тооцон хураамжийн хэмжээг тогтоох болоод байна. Цахим даатгалын зах зээл нь өртөг өндөртэйгөөс гадна өнөөг хүртэлх цахим сүлжээний эрсдэлийн түүхэн мэдээлэл дутмаг байгаа нь тохиромжтой үнэ тарифыг тодорхойлоход бэрхшээл учруулж байна. Цахим халдлагын давтамж цөөн байдаг боловч тухайн тохиолдлууд нь өргөн хүрээг хамарсан, томоохон хэмжээний эрсдэлүүдийг дагуулдаг.


Цахим даатгалын эрсдэлийг шууд болон шууд бус байдлаар даатгах боломжтой. Шууд эрсдэлийн даатгалд мэдээллийн халдлагын даатгал хамрах бол шууд бус даатгалд гэнэтийн ослын, агаарын, газрын болон усан замын, тээврийн хэрэгслийн, орон байрны зэрэг тодорхой цахим эрсдэл гэж зааж өгөөгүй даатгалын төрлүүд хамаарна. Английн Банкны судалгаанд цахим сүлжээний шууд бус буюу чимээгүй халдлагаас улбаалан үүсэж болох боломжит гарз хохирлын талаар дурдаж, удирдлагын түвшин дэх материаллаг хохирлуудыг тодорхойлжээ.

Эх сурвалж: GIMAR 2016, IAIS

Даатгалын гүнзгийрэлтийн түвшин: Даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д эзлэх хураамжийн орлогын хувь хэмжээ 2016 оны байдлаар 0.48 хувь байгаа нь

өнгөрсөн онтой харьцуулахад 0.01 нэгжээр буурсан үзүүлэлт юм.

Зураг 9: Даатгалын гүнзгийрэлтийн түвшин




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүрүүд болох даатгалын гүнзгийрэлт, нягтрал нь олон улсын түвшинтэй харьцуулахад доогуур байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага(OECD)-ын 2016 оны “Дэлхийн даатгалын зах зээлийн хандлага” судалгаанд дурдсанаар Европын орнууд(Франц, Итали, Швейцар, Англи г.м) болон Азийн зарим орнуудад(Япон, Солонгос, Сингапур г.м) урт хугацааны даатгалын гүнзгийрэлтийн түвшин 5 хувиас дээгүүр байгаа бол Өмнөд Африк болон

Ирландад 10 хувиас дээш байгаа юм. Харин ердийн даатгалын гүнзгийрэлтийн түвшин 2015 онд ердөө 3 орнуудад(Солонгос, Пуэрто Рико, АНУ) л 5 хувиас дээш хувьтай байжээ

Нийт хөрөнгө: Салбарын хэмжээнд нийт хөрөнгөд эзлэх хувиар авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 79.6 хувь, давхар даатгалын компани 16.8 хувь, урт хугацааны даатгалын компани 3.6 хувийг тус тус эзэлж байна. Даатгалын компаниудын хөрөнгийн дундаж өсөлт 18 хувьтай байна.

Зураг 10: Даатгалын салбарын нийт хөрөнгө




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 20.3 хувиар буюу 35.2 тэрбум төгрөгөөр өсөж 208.4 тэрбум төгрөгт хүрэв. Ердийн даатгал болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө харгалзан 18.9 хувь, 34.5 хувиар өсөж тус тус 165.8 тэрбум, 35.0 тэрбум төгрөгт хүрсэн бол урт хугацааны даатгалын нийт хөрөнгө 1.5 хувиар буурч 7.5 тэрбум төгрөг болов.

Долоон компанийн нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20-оос дээш хувиар өссөн байна.

Хураамжийн орлого: Тайлант хугацаанд даатгалын салбарын хураамжийн орлого өмнөх оноос 0.2 хувиар буюу 189.2 сая төгрөгөөр өсөж, 114.5 тэрбум төгрөгт хүрэв. Нийт хураамжийн орлогын 97.5 хувь буюу 111.7 тэрбум төгрөгийг ердийн даатгалын 15 компани бүрдүүлж байгаа бол урт хугацааны даатгал 1.3 тэрбум төгрөгийн, хөдөө аж ахуйн давхар даатгалын компани 1.6 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллажээ.

Зураг 11: Хураамжийн орлого




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж: Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал жилийн эцсийн байдлаар 34.3 тэрбум төгрөгт хүрч, нийт хураамжийн орлогын 29.9 хувийг эзлэв. Үүнээс ердийн

даатгалын компаниудын нөхөн төлбөр 97.4 хувийг бүрдүүлж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 4.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 12: Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Нийт нөхөн төлбөрийн 43.2 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 23.1 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 13.1 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгал, 6.9 хувийг санхүүгийн даатгал, 6.0 хувийг хөрөнгийн даатгал, харин 7.7 хувийг бусад даатгалын хэлбэрүүд эзэлж байна.

Тайлант хугацаанд нийт 37.8 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг шилжүүлсэн нь өмнөх оноос 10.3 хувиар буурч, нийт хураамжийн орлогын 33 хувийг эзэлж байна. Ердийн даатгалын компаниуд давхар даатгалд 37.2 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компани 24.5 тэрбум төгрөгийг төлжээ.

Нөөц сан: Тайлант жилд даатгалын салбарын нөөц сангийн хэмжээ (орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг

нэмж тооцов) өмнөх оны мөн үеэс 27.7 хувиар өсөж, 93.0 тэрбум төгрөгт хүрэв.

Зураг 13: Нөөц сангийн хэмжээ, өсөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нөөц сангийн хөрөнгийн дийлэнх хувь нь арилжааны банкуудад хадгаламж болон хадгаламжийн сертификат хэлбэрээр байршиж байна.

2.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Банк бус санхүүгийн байгууллагууд нь хуулийн хүрээнд нийт 10 төрлийн ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй бөгөөд үүнийг гадаад валютын, зээл санхүүжилтийн, хөрөнгө удирдлагын гэж ангилах болсон.

2016 оны байдлаар СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр 518 ББСБ-ын 416 нь зээл санхүүжилтийн, 54 нь гадаад валютын, 48 нь хөрөнгө удирдлагын үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 14: Банк санхүүгийн байгууллагын бүтэц




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Эдийн засагт үзүүлэх нөлөө: Банк бус санхүүгийн байгууллагууд нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх үүрэгтэйгээр оролцдог тул эдийн засгийн хүртээмжид нөлөөлдөг. Иймд 2016 оны байдлаар ББСБ-ын нийт

хөрөнгө ДНБ-ний 3.3 хувьтай тэнцсэн ба 2015 оны дүнгээс 0.6 нэгжээр өссөн байна. 2016 онд ББСБ-уудын нийт хөрөнгө 787.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 26 хувиар өслөө.

Зураг 15: Нийт хөрөнгө ба ДНБ-ний харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-уудын тоо: ББСБ-уудын тоо 2009 оноос өсөж эхэлсэн ба 2013 оноос өсөлтийн хурд нэмэгдэж 25 хувь болсон. 2016 онд нийт ББСБ-ын тоо 518-д хүрсэн ба өмнөх оноос 15 хувиар өссөн байна. Тайлант онд

72 ББСБ-д үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 4 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов.

Зураг 16: ББСБ ба харилцагчдын тоо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдүүдэд үндсэн 3 чиглэлээр тусгай зөвшөөрөл олгож байгаа ба үүнээс зээл санхүүжилтийн үйл ажиллагааг 416 ББСБ 480.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг бүрдүүлэн ажиллаж байгаа бол хөрөнгө удирдлагын 48 ББСБ 290.8 тэрбум төгрөг, валют арилжааны 54 ББСБ 15.8 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй байна. Нийт хөрөнгийн харьцаа зээл санхүүжилт, хөрөнгө удирдлага, валют арилжааны ББСБ-уудад тус тус 61:37:2 байна.

ББСБ-уудын зах зээлд эзлэх хувь: Банк бус санхүүгийн салбарын 40 хувийг 21 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байгаа бол нийт орлогын 54.3 хувийг 22 ББСБ-ын орлого бүрдүүлж байна.

Зураг 17: ХЗХ-ны бүтэц




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-дын тоо: 2016 онд СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу 280 ХЗХ үйл ажиллагаа явуулж өмнөх оноос 10.8 хувиар өслөө. Улаанбаатар хотын хэмжээнд нийт 184, орон нутагт 96 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж

байгаа бөгөөд нийт 46,183.0 гишүүнтэй байна. ХЗХ-дын нийт гишүүдийн 57.8 хувь нь Улаанбаатар хотын, 42.2 хувийг орон нутгийн гишүүд тус тус эзэлж байна.

Зураг 18: ХЗХ-д ба гишүүдийн тоо /мянгаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Эдийн засагт үзүүлэх нөлөө: Нийт хөрөнгийн хэмжээ 2016 оны 4 дүгээр улирлын байдлаар 113.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15.4 тэрбум төгрөг буюу 15.8 хувиар өслөө. Мөн ХЗХ-дын банкин дахь харилцах

дансны үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өсөж 7.98 тэрбум төгрөгт, хадгаламжийн хэмжээ 6.6 хувиар өсөж 13.3 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.

Зураг 19: Нийт хөрөнгө ба ДНБ-ний өөрчлөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийслэлийн төсөл хөтөлбөрт хамрагдсан ХЗХ: 2016 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 118 ХЗХ нийслэлийн төсөл хөтөлбөрөөр тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр нь нийт 280 ХЗХ-дын 42 хувийг эзлэх

боловч нийт хөрөнгийн 12.0 хувийг эзэлж байна. Нийт гишүүдийн тооны 20 хувь буюу 9,167 гишүүн нийслэлийн төсөл хөтөлбөрт хамрагдсан хоршоонд бүртгэлтэй байна.





ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

3.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

3.1.1 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ


Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш “ҮЦТХТ” ХХК-ийн төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр үнэт цаасны нийт 886,590, холболтын 139,228 данс нээгдсэн. Монгол Улсад 15 наснаас дээш насны 2,182,417 иргэн байгаа бөгөөд тэдгээрийн 41 хувь нь үнэт цаасны данс эзэмшиж байна.

Нийт дансыг бүтцээр нь үзвэл 881,962 дотоодын иргэн, 1,920 гадаадын иргэн, 2,530 дотоодын аж ахуйн нэгж, 178 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна. Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 81017 данс шинээр нээгдсэнээс 80899 нь дотоодын иргэн, 66 нь гадаадын иргэн, 50 нь дотоодын аж ахуйн нэгж, 2 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд “ҮЦТХТ” ХХК-д шинээр нээгдсэн дансны тоо 81017 болтол огцом өсөлтийг үзүүлсэн нь ЗГ-аас “Сайн хувьцаа” хөтөлбөр хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг худалдах захиалга өгөн, шинээр данс нээх болсон нь гол нөлөөг үзүүлсэн.

Арилжааны бус хэлцэл болох өв залгамжлалын нийт 248 гүйлгээ хийгдэж, давхардсан тоогоор 123 ХК-ийн 254,343 ширхэг хувьцаа, бэлэглэлээр 19 гүйлгээ хийгдэж, давхардсан тоогоор 21 ХК-ийн 145,353 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг тус тус шилжүүлсэн байна.

Зураг 20: “ҮЦТХТ” ХХК-д нээгдсэн дансны тоо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны үнийн дүнд гадаадын аж ахуйн нэгж болон иргэдийн эзлэх хувь 0.02 нэгж буюу 2.4 хувьтай байгаа

бол дотоодын аж ахуйн нэгж болон дотоодын иргэдийн эзлэх хувь 0.98 нэгж буюу 97.6 хувьтай байна.

Зураг 21: Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Гадаадын хөрөнгө оруулагчдын эзлэх хувь буурах хандлагатай байгаа нь зөвхөн Монгол Улсад бий болоод буй асуудал биш бөгөөд Азийн зарим орнуудад мөн тохиогоод байна. Иймд гадаад хөрөнгө оруулагч нар зугтах хандлагатай байгаа дээрх орнууд хөрөнгө оруулагч

нарын итгэлийг сэргээхэд чиглэсэн бодлого баримтлах нь ихээхэн чухал байна.

Үнэт цаасны зах зээлийн оролцогчид: Тайлант хугацаанд СЗХ-ны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 302 компани бүртгэлтэй байна.

Хүснэгт 3: Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо

Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц	Санхүүгийн зохицуулах хороо
Төрийн өмчит	31
Төрийн өмчийн оролцоотой	19
Хувийн өмчит	252
Нийт	302

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2013–2016 оны хооронд СЗХ-ны зүгээс хөрөнгийн биржийн нэр хүндийг өсгөх, үнэт цаасны бүртгэлийн ангиллыг шинэчлэх, СЗХ-ны бүртгэлийг бүртгэлийн хэлбэрээс зөвшөөрлийн хэлбэрт шилжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд өмч хөрөнгө нь үрэгдсэн, хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн

үүргээ сүүлийн 3-аас дээш жилийн хугацаанд тогтмол биелүүлээгүй компаниудын үнэт цаасыг бүртгэлээс хасах, хууль хяналтын байгууллагуудад шилжүүлэх хийгээд компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 4: Хувьцаат компанийн хувьцааны бүтэц

Үнэт цаас гаргагчийн ангилал	2014 он	2015 он	2016 он
Төрийн мэдлийн бус хувьцаа	2,913,776	2,809,930	4,160,854
Төрийн мэдлийн хувьцаа	2,254,152	2,246,316	2,818,124
Орон нутгийн оролцоотой	29,046	29,046	29,046
Нийт	5,196,974	5,085,292	7,008,024
Эрдэнэс Тавантолгой /Иргэн/	967,134	2,558,176	2,212,224
Эрдэнэс Тавантолгой /ААН/	4,915	5,139	5,203
Эрдэнэс Тавантолгой /Төр/	14,027,951	12,436,685	12,782,573
Нийт	15,000,000	15,000,000	15,000,000
Хаалттай ХК	-	172,753	174,958
Нийт	-	172,753	174,958

Эх сурвалж: "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК

Ашигт малтмалын тухай хуулийн 5.6–д заасны дагуу 15 стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдийн хувьцааны 10 хувийг хөрөнгийн биржээр арилжаалах хуулийн шаардлагыг хэрэгжүүлэх нь үнэт цаасны зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог тэлэх ач холбогдолтой бөгөөд дээрх ордын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдүүдээс нэр бүхий 4 компани нээлттэй хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд 62 ҮЦК СЗХ–ноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 12 компани үйл ажиллагаа явуулж байгаа бол хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 37 этгээд үйл ажиллагаа явуулж байна. СЗХ–ноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 5: Зохицуулалттай этгээдийн тоо

Д/д	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	Оролцогчдын тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны	1
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	12
5	Брокер, дилер	62
6	Кастодиан банк	3
7	Андеррайтер /давхардсан тоогоор/	25
8	Хөрөнгө оруулалтын зөвлөх /давхардсан тоогоор/	15
	Нийт	81
9	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
10	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	37
11	Аудитын компани	44
12	Үнэлгээний компани	20
13	Хуулийн компани	19

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 компанид олгосон бол ЗГ-ын 2015 оны 147 дугаар тогтоол, Сангийн сайдын 2015 оны 280 дугаар тушаалын дагуу 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс “ҮЦТТХТ” ХХК-ийг үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий бие даасан 2 хуулийн этгээд болгон өөрчлөн зохион байгуулах чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллав.


Хорооны 2015 оны 312 дугаар тогтоолоор “Монголын үнэт цаасны бирж” ХХК-д үнэт цаасны арилжаа эрхлэх, үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд ингэснээр үнэт цаасны зах зээлд хувийн хөрөнгө оруулалттай хоёр шинэ бирж байгуулагдан үйл ажиллагаа явуулах боломж бүрдээд байна.

“Монголын үнэт цаасны бирж” ХХК нь үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны бүртгэл, арилжаа, тооцооны үйл ажиллагаагаа эхлүүлэх бэлтгэлийг ханган ажиллаж байна.

3.1.2 ХАА-Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөдөө аж ахуйн биржийн гишүүн 37 брокерын компани үйл ажиллагаа явуулж байгаагаас 18 брокер хөдөө орон нутагт байрладаг бөгөөд төвийн бүсэд 5, хангайн бүсэд 3, баруун бүсэд 8, зүүн бүсэд 2 брокер тус тус ажиллаж байна.

Зураг 22: Хөдөө орон нутгууд дахь брокеруудын байршил



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Харин үлдсэн 19 брокер Улаанбаатар хотод төвлөрөн ажилладаг бөгөөд нийслэлийн нийт 9 дүүргийн 6-д нь брокер, дилерийн үйл ажиллагааг эрхэлж байна.

Зураг 23: ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн арилжаа /бүтээгдэхүүнээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Хөдөө аж ахуйн биржээр дамжин 8 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагддагаас, тайлант үед нийт 5 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан. Эдгээр нь ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, бодын хөөвөр болон завод ноос болно. Бүтээгдэхүүн тус бүрийг арилжигдсан хэмжээгээр нь өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзлээ. Үүнд ямааны ноолуур өмнөх оны мөн үеийнхээс 7 хувиар, хонины ноос 47 хувиар, тэмээний ноос 66 хувиар тус тус өссөн бол завод ноосноос ямааны завод ноос арилжаалагдаж 11 хувиар буурсан, харин сарлагийн

завод ноос 2016 онд шинээр арилжаалагдаж эхэлсэн байна. Бодын хөөврийн хувьд мөн 2016 онд шинээр арилжаалагдаж эхэлсэн.

3.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг.

Зураг 24: Даатгалын нягтрал /төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, УСХ

2015 оны жилийн эцэст нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ 37,261.5 төгрөг байсан бол 2016 оны жилийн эцэст 561.3 төгрөгөөр буюу 1.5 хувиар буурч 36,700.1 төгрөгт хүрэв. Хураамжийн орлогын өсөлт хүн амын өсөлтөөс удаан байсан нь тус бууралтад нөлөөлөв.

Даатгалын нягтралыг ангиллаар авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 2.5 хувиар буурч 35,794.5 төгрөг болсон бол урт хугацааны даатгалын хураамж 67.4 хувиар өсөж 905.6 төгрөгт хүрсэн байна.

Зураг 25: Даатгалын компани болон зуучлагчдын салбаруудын байршил //аймгуудаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт нь даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Хөдөө орон нутагт нийт 284

даатгалын компани, зуучлагчийн салбар байгаа бөгөөд нэг аймагт дунджаар 14 салбар нэгж ногдож байна.

Зураг 26: Даатгалын компани болон зуучлагчдын салбаруудын байршил /дүүргээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд Улаанбаатар хотын нийт дүүрэгт даатгалын компани болон зуучлагчийн 158 салбар нэгж бүртгэгдэв. Нийт салбар нэгжийн 80 орчим хувь төвийн 5 дүүрэгт төвлөрсөн байна.

Түүнчлэн БНСУ болон БНХАУ-д тус тус 1 салбар нэгж үйл ажиллагаа явуулж байна.

3.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА


ББСБ-ын байршил: ББСБ-уудын хүртээмжтэй байдлыг бүс нутаг, дүүргээр ангилан 10,000 хүн болон 100 аж

ахуй нэгжид ногдох ББСБ-ын тоогоор гаргалаа. Ийнхүү тооцоход улсын дүнгээр 10,000 хүнд 0.3, 100 аж ахуй нэгжид 0.1 ББСБ ногдож байна.

Бүс нутгийн хэмжээнд 10,000 хүнд 0.6, 100 аж ахуйн нэгжид 0.35 ББСБ байгаа бол хамгийн олон ББСБ байршсан төвийн бүс болох Дархан-Уул болон Төв аймгуудад ББСБ хамгийн их ба хөдөө, орон нутаг дахь ББСБ-уудын нийт хөрөнгийн ихэнх нь төвлөрчээ.

Тухайлбал, 10,000 хүнд ногдох ББСБ төвийн бүсэд 0.8, зүүн бүсэд 0.7, хангайн бүсэд 0.6, баруун бүсэд 0.2 байгаа бол 100 аж ахуйн нэгжид ногдох ББСБ-ын тоо төвийн болон зүүн бүсэд тус тус 0.45, хангайн бүсэд 0.42, баруун бүсэд 0.11 ногдож байна.

Зураг 27: ББСБ-уудын хүртээмж /бүс нутгаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Улаанбаатар хотод 10,000 хүнд 4, 100 аж ахуйн нэгжид 1.2 ББСБ ногдож байгаа нь бүс нутгаас 6:3 дахин их байна. Дүүргүүдийн хэмжээнд 10,000 хүнд ногдох ББСБ Хан-Уул дүүрэгт 10.3, Баянгол дүүрэгт 7.7, Чингэлтэй дүүрэгт 5.3,

Сүхбаатар дүүрэгт 3.6, бусад дүүрэгт 1.7 байна. 100 аж ахуйн нэгжид ногдох ББСБ Хан-Уул дүүрэгт 3.2, Баянгол дүүрэгт 1.7, бусад дүүрэгт 0.8 байна. Харин Багахангай дүүрэгт огт ББСБ-ын үйлчилгээ үүсээгүй байна.

Зураг 28: ББСБ-уудын хүртээмж /дүүргүүдээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ–уудын зээлийн тархалт: ББСБ–уудын зээлдэгчдийн тоо, үлдэгдлийн хэмжээг аймгуудыг бүсчлэн, нийслэлийг дүүргүүдээр ангилан зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг 464 ББСБ–ын хувьд тооцоолол хийлээ.

Бүс нутгууд дундаас төвийн бүсэд 2246 зээлдэгч үйлчлүүлж, 10.7 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй буюу хамгийн их байна. Харин зүүн бүсэд хамгийн бага буюу 770 зээлдэгч, 1.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Зураг 29: Бүс нутгууд дахь зээлийн тархалт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлдэгчдийн тоо, зээлийн үлдэгдлийн хэмжээгээр төвийн дүүргүүд болох Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол дүүргүүдэд илүү төвлөрсөн байна. Тухайлбал, зээлдэгчдийн тоо Чингэлтэй дүүрэгт 26,743, Сүхбаатар дүүрэгт 15,911, Баянгол дүүрэгт 9,731, Сонгинохайрхан дүүрэгт 4,707, Баянзүрх дүүрэгт 2,598, Хан–уул дүүрэгт 1,536, Налайх дүүрэгт 440, Багануур дүүрэгт 63 байна.

Зээлийн дүнгээр мөн дээрх төвийн дүүргүүдэд төвлөрсөн ба нийт зээлийн үлдэгдэл Сүхбаатар дүүрэгт 173.9 тэрбум төгрөг буюу 37.0 хувь, Чингэлтэй дүүрэгт 139.3 тэрбум төгрөг буюу 30.0 хувь, Баянгол дүүрэгт 77.1 тэрбум төгрөг буюу 17.0 хувь, Хан–Уул дүүрэгт 32.4 тэрбум төгрөг буюу 7.0 хувь, Баянзүрх дүүрэгт 27.2 тэрбум төгрөг буюу 6.0 хувь, Сонгинохайрхан дүүрэгт 14.2 тэрбум төгрөг буюу 3.0 хувь, Налайх болон Багануур дүүрэгт нийлээд 0.8 тэрбум төгрөг буюу 0.2 хувь байна.

Зураг 30: Дүүргүүд дэх зээлийн тархалт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


3.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ–дын байршил: Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 280 ХЗХ–оос 65.7 хувь буюу 184 нь Улаанбаатар хотод, 34.3 хувь буюу 96 нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна. ХЗХ–д банк, санхүүгийн үйлчилгээний төвлөрөл, хүн амын нягтралаа дагаад Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд хамгийн их төвлөрсөн байна.

Хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ–дын хувьд тархалт Орхон, Баян–Өлгий, Завхан аймгуудад хамгийн их байгаа бол Ховд, Говь–Алтай, Говь–Сүмбэр

аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна. Орон нутаг дахь ХЗХ–дын тоо нэмэгдсэнээр иргэдийг бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрээр дэмжих зэрэг стратегийн чухал ач холбогдолтой юм. Хөдөө орон нутагт 96 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд байршлыг бүсээр авч үзвэл баруун бүсийн аймгуудад хамгийн их буюу 30, хангайн бүсэд 28, төвийн бүсэд 25, зүүн бүсэд 13 ХЗХ тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 31: ХЗХ–дын тоо /бүс нутгаар/





Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт ХЗХ–дын тоо болон салбарын байршил нийслэл Улаанбаатар хотод илүү тархсан бөгөөд тархалтыг 10,000 хүнд болон 100 ААН–д ногдох тоогоор харууллаа. Аймаг орон нутгийн хувьд 10000 хүнд ногдох ХЗХ–дын тоо

баруун бүсэд 0.8 , хангайн бүсэд 0.7 байгаа бол Нийслэл хотын хувьд Чингэлтэй дүүрэгт хамгийн их буюу 4.8 байна.

Зураг 32: ХЗХ–дын хүртээмж /байршлаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ–дын тооны өсөлт: ХЗХ–дын тооны өсөлт 2010 оноос тасралтгүй өссөн бөгөөд 2015 онд хамгийн өндөр өсөлт буюу 59.1 хувьд хүрч 2016 онд огцом буурлаа. Нийслэлийн

хоршоодын тооны өсөлт орон нутагтай харьцуулахад илүү байна. Энэ нь нийслэлийн төсөл хөтөлбөрөөр бий болсон ХЗХ–дын тооны өсөлттэй холбоотой.

Зураг 33: ХЗХ–дын тоо, өсөлтийн хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Монгол Улсад банкнаас бусад санхүүгийн зах зээлийн үйлчилгээг үзүүлэгч байгууллагууд Улаанбаатар хотод илүү төвлөрсөн ба хөдөө орон нутагт уг үйлчилгээнүүдийн тархалт жигдхэн байна. Цаашид харилцагчдын хэрэгцээнд тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг тэдэнд санал болгоход санхүүгийн зуучлагчид анхааран, бодлого

тодорхойлогч, зохицуулагч болон мэргэжлийн холбоод нь хөрөнгө оруулагч, даатгуулагч, харилцагчдын санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх, эрх ашгийг хамгаалахад бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.





БҮТЭЭГДЭХҮҮН,
ҮЙЛЧИЛГЭЭ

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

4.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

4.1.1 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт: 2016 онд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан нийт 348.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн нь өмнөх

оны мөн үетэй харьцуулахад 36.1 хувиар буурчээ. Нийт арилжааны 14.1 хувийг хувьцаа, 85.9 хувийг ЗГҮЦ-ны арилжаа тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 6: Үнэт цаасны арилжааны үзүүлэлт


Үнэт цаасны төрөл		Хийгдсэн арилжааны тоо	Арилжагдсан тоо хэмжээ /сая ширхэг/	Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/
Хувьцаа	Анхдагч зах зээл	1	33.9	6.3
	Хоёрдогч зах зээл	244	59.8	42.7
ЗГҮЦ	Анхдагч зах зээл	31	3.1	280.5
	Хоёрдогч зах зээл	77	0.196	19.2

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Хувьцааны арилжаа: “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 244 удаагийн арилжаагаар 126 компанийн 93.7 сая ширхэг хувьцааг 49.0 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна. Хувьцааны арилжааны 69.6 хувь буюу 34.1 тэрбум

төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, үлдэх 30.4 хувь буюу 14.9 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа тус тус бүрдүүлсэн.

Зураг 34: Хувьцааны арилжаа /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тендер саналын арилжаагаар нэр бүхий хоёр хувьцаат компанийн 19.1 мянган ширхэг хувьцааг 97.0 сая төгрөгөөр арилжсан байна.

Хорооны зүгээс үнэт цаасны зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, өөрийгөө зохицуулах байгууллагын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор үнэт цаасны бүртгэлийн журамд зохицуулалтын өөрчлөлт хийснээр СЗХ болон биржийн чиг үүргийн давхардлыг бууруулж, компаниуд хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлж, урт хугацааны санхүүжилтийг татах орчныг улам хялбаршуулсан алхам болоод байна.

Засгийн газрын үнэт цаасны арилжаа: 2014 оны 11 дүгээр сараас “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаас арилжаалагдаж эхэлснээс хойш нийт 826.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 8.8 сая ширхэг үнэт цаас анхдагч зах зээл дээр арилжаалсан байна.

2015 оны жилийн эцсийн байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан нийт 510.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 5.4 сая ширхэг ЗГҮЦ-ыг анхдагч зах зээлээр 5.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий 52.3 мянган ширхэг үнэт цаасыг хоёрдогч зах зээлээр тус тус арилжаалсан байна.

Анхдагч зах зээлийн арилжаа: 2016 онд нийт 31 удаагийн ЗГҮЦ-ны арилжаагаар 3.1 сая ширхэг үнэт цаасыг 280.5 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Үүнд 12 долоо

хоногтой үнэт цаас нийт арилжааны 30.3 хувийг, 28 долоо хоногтой үнэт цаас 31.7 хувь, 39 долоо хоногтой үнэт цаас 22.9 хувь, 52 долоо хоногтой үнэт цаас 13.3 хувийг, 2 болон 3 жилийн урт хугацаатай үнэт цаас 1.8 хувийг тус тус эзэлж байна.

Хоёрдогч зах зээлийн арилжаа: ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр нээсэн бөгөөд 2016 онд нийт 196.4 мянган ширхэг үнэт цаас 19.2 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан.

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан арилжаалагдсан ЗГҮЦ-ны хэмжээ буурсан нь биржийн нийт үнэт цаасны арилжааны үнийн дүн буурахад голлох нөлөө үзүүлжээ. Мөн макро эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал муудсантай холбоотойгоор ЗГ-ын зүгээс төсвийн алдагдлыг үнэт цаас гарган нөхөх бодлогын арга хэмжээг өөрчилсөн, мөн дотоодын зах зээлээс үнэт цаас гарган санхүүжилт татахад хүндрэлтэй байгаа нь ЗГҮЦ-ны нийлүүлэлт буурахад тус тус нөлөөлсөн байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа: Тайлант хугацаанд “МИК ОССК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “МИК актив найм ТЗК” ХХК, “МИК актив ес ТЗК” ХХК, “МИК актив арав ТЗК” ХХК, “МИК актив арван нэг ТЗК” ХХК гэсэн дөрвөн тусгай зориулалтын компанийн нийт 7730 зээлдэгчдийн зээлийн багц бүхий 501.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн байна.

Хүснэгт 7: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөгөөр/

ХБҮЦ гаргагч	Нийт гаргасан үнэт цаас	"ҮЦТХТ" ХХК-д бүртгэгдсэн	Зээлдэгчийн тоо
“МИК актив нэг ТЗК” ХХК	328.1	322.9	6,658
“МИК актив хоёр ТЗК” ХХК	224.8	222.1	5,290
“МИК актив гурав ТЗК” ХХК	328.5	324.6	6,593
“МИК актив дөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9,510
“МИК актив тав ТЗК” ХХК	301.2	294.3	5,805
“МИК актив зургаа ТЗК” ХХК	267.8	261.7	5,188
“МИК актив долоо ТЗК” ХХК	299.6	293.8	5,414
“МИК актив найм ТЗК” ХХК	189.8	186.3	3,291
“МИК актив ес ТЗК” ХХК	137.5	137.2	1,719
“МИК актив арав ТЗК” ХХК	103.0	-	1,585
“МИК актив арван нэг ТЗК” ХХК	70.9	-	1,135
Нийт	2,710.6	2,495	52,188

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

“МИК ОССК” ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах хүрээнд тусгай зориулалтын компаниудыг үүсгэн байгуулж, СЗХ-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах зөвшөөрөл аван ажиллаж байна. Монгол Улсын засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлсэн “Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалаар “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг 2013 онд эхлүүлснээс хойш “МИК ОССК” ХХК-ийн үүсгэн байгуулсан 11 тусгай зориулалтын компанид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, нийт 52,188 зээлдэгчийн зээлийн багц бүхий 2.7 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн байна.

4.1.2 ХАА-Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

2013 оны 4 дүгээр сард биржээр дамжин зөвхөн нэг төрлийн түүхий эд буюу ямааны ноолуур арилжаалагддаг байсан бол 2016 оны 4 дүгээр улирлын байдлаар бараа бүтээгдэхүүний төрөл нэмэгдэж 8 төрлийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалагддаг болсон байна. Үүнд: ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, завод ноос, бодын хөөвөр, хүнсний буудай, мал бэлтгэл болон тосны ургамал зэрэг багтдаг. Завод ноос нь адууны, хонины, ямааны, сарлагийн, тэмээний гэж 5 ангилалддаг бол бодын хөөвөр нь сарлагийн, адууны, үхрийн гэсэн 3 ангилалд хуваагддаг.

2016 оны 4 дүгээр улирлын байдлаар эдгээр 8 төрлийн түүхий эдээс нийт 5 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан ба үүнд завод ноосноос зөвхөн ямааны болон сарлагийн завод ноос, харин бодын хөөврөөс зөвхөн сарлагийн хөөвөр багтана.

2016 онд арилжааны хэмжээгээрээ хонины ноос хамгийн их буюу 16,150.0 тонн, сарлагийн завод ноос хамгийн бага буюу 1.1 тонн арилжаалагдсан байна. Харин арилжааныхаа дүнгээр ямааны ноолуур 409.6 тэрбум төгрөг буюу нийт арилжааны 88 хувийг эзэлж байсан бол сарлагийн завод ноос 1 хүрэхгүй хувийг эзэлсэн байна.

Хүснэгт 8: 2016 оны ХАА-н биржийн арилжааны хэмжээ, дүн

Д/д	Барааны нэр	Барааны хэмжээ /тонн/	Арилжааны дүн /тэрбум төгрөг/	Эзлэх хувь
1	Ямааны ноолуур	7,216	409.64	88.48
2	Хонины ноос	16,150	26.15	5.65
3	Тэмээний ноос	744	3.91	0.84
4	Бодын хөөвөр			
4.1	Сарлагийн хөөвөр	4.1	0.06	0.01
6	Завод ноос			
6.1	Ямааны завод ноос	1,639	23.24	5.02
6.2	Сарлагийн завод ноос	1.1	0.003	0.0006
	Нийт	25,754.2	463	100

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


4.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

2016 оны байдлаар ердийн болон урт хугацааны даатгалын нийт 23 төрлийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ байна. Даатгалын нийт хураамжийн орлогоос ердийн даатгал 97.5 хувь буюу 111.7 тэрбум төгрөг, урт хугацааны даатгал 1.1 хувь буюу 1.3 тэрбум төгрөг, давхар даатгал 1.4 хувь буюу 1.6 тэрбум төгрөгийг тус тус эзэлжээ. Харин нийт нөхөн төлбөрийн зардалд ердийн даатгал 97.4 хувь буюу 33.4 тэрбум төгрөг, урт хугацааны даатгал 2.6 хувь буюу 886.0 сая төгрөг, давхар даатгал 0.01 хувь буюу 4.6 сая төгрөгийг тус тус эзэлж байна.

Даатгалын нийт хураамжийн орлогын бүтцэд хөрөнгийн даатгал 27.8 хувь, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 24.3 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 12.6 хувь, гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал 10.8 хувь, хариуцлагын даатгал 6.9 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 15.2 хувийг бусад ердийн даатгалын хэлбэрүүд, 1.1 хувийг урт хугацааны даатгал, 1.4 хувийг хөдөө аж ахуйн давхар даатгал тус тус бүрдүүлсэн.

Даатгалын зуучлагчид: 2016 онд тусгай зөвшөөрөл авсан нийт 40 даатгалын зуучлагч компани үйл ажиллагааг явуулж даатгалын нийт хураамжийн орлогын 21.4 тэрбум төгрөгийг буюу 18.7 хувийг зуучлагчид бүрдүүлэв.

Зураг 35: Нийт зуучлагчдын даатгалын хураамжийн орлого /бүтцээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Харин тайлант жилд даатгалын зуучлагч компаниуд нийт 30.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласнаас даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж буй 8 банк зуучлагчдын хураамжийн орлогын 50.9 хувийг бүрдүүлжээ. Даатгалын зуучлагчдын нийт хураамжийн орлогыг бүтцээр авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 32.8 хувь, хөрөнгийн даатгал 24.6 хувь, зээлийн даатгал 19.9 хувь,

авто тээврийн хэрэгслийн даатгал 8.5 хувь, хариуцлагын даатгал 4.6 хувь, бусад даатгалын хэлбэрүүд 9.6 хувийг тус тус эзэлсэн.

Даатгалын төлөөлөгч: Тайлант хугацаанд даатгалын төлөөлөгчид нийт хураамжийн орлогын 25.9 хувь буюу 29.6 тэрбум төгрөгийг бүрдүүлжээ.

Зураг 36: Даатгалын төлөөлөгчөөр дамжиж орсон хураамжийн орлого



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын төлөөлөгчөөр дамжин орсон хураамжийн орлогод жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 30.0 хувь, хөрөнгийн даатгал 21.5 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 20.3 хувь, гэнэтийн осол, эмчилгээний


даатгал 14.0 хувь, хариуцлагын даатгал 5.5 хувь, агаарын хөлгийн даатгал 3.7 хувь, бусад даатгалын хэлбэрүүд 5.0 хувийг тус тус эзэлж байна.

4.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ-уудын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон орлого: 2016 онд ББСБ-ууд нийтдээ 8 төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс 142.5 тэрбум төгрөгийн орлого олсон. Үүний 94 хувь буюу 133.7 тэрбум төгрөгийг зээлийн хүүгийн орлого, 2.8 хувийг буюу 4.0 тэрбум төгрөгийг санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээнээс,

2.76 хувь буюу 3.9 тэрбум төгрөгийг гадаад валютын арилжаанаас, 0.5 хувь буюу 0.7 тэрбум төгрөгийг мөнгөн гуйвуулгын үйлчилгээнээс, 0.1 хувь буюу 0.1 тэрбум төгрөгийг үнэт цаасны арилжаанаас, 0.03 хувь буюу 0.05 тэрбум төгрөгийг факторингийн үйлчилгээнээс тус тус бүрдүүлжээ.

Зураг 37: ББСБ-уудын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон орлого




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-дын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон орлого: 2016 онд 280 ХЗХ-ны бүтээгдэхүүн үйлчилгээнээс олсон орлогын хувьд зээлийн хүүгийн орлого 90.4 хувь буюу 22.3 тэрбум төгрөг, банк санхүүгийн байгууллагаас авсан

хүүгийн орлого 1.2 тэрбум төгрөг, зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого 0.3 тэрбум төгрөг, үнэт цаасны хүүгийн орлого 96.0 мянган төгрөг, санхүүгийн түрээсийн орлого 20,500.0 төгрөгөөс тус тус бүрдэж байна.

Зураг 38: ХЗХ-дын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон орлого



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-дын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс гарсан зардал: 2016 онд ХЗХ-д нийт 20.9 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ. Үүнээс хадгаламжийн хүүгийн зардал 56.5 хувь буюу 11.8 тэрбум төгрөг, банк

санхүүгийн байгууллагад төлсөн зардал 2.9 хувь, бусад хүүгийн зардал 0.3 хувь, санхүүгийн түрээсийн зардал 0.0004 хувийг тус тус эзэлсэн байна.

Зураг 39: ХЗХ-дын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс гарсан зардал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Тайлант онд ХЗХ-д 3.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 16 хувийн цэвэр ахиуц ашигтай ажиллажээ. Цэвэр ахиуц ашиг өмнөх оны мөн үеэс 5 нэгжээр буурсан

ба үүнд нийт орлого 30 хувиар өссөн хэдий ч, нийт зардал 39 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.



ИНФОГРАФИК

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын салбарын нийт хөрөнгө /Тэрбум төгрөг/



Даатгалын нөөц сан /Тэрбум төгрөг/




Хохирлын харьцаа /Хувиар/

Нийт хураамжийн орлого /Тэрбум төгрөг/

Year	Total Dividend Income (TBD)	Dividend Income per Share (MNT)	Dividend Yield (%)
2016	114.5	36.7	0.48%
2015	114.3	37.3	0.49%
2014	108.7	36.3	0.49%
2013	93.9	32.1	0.49%
2012	78.8	27.5	0.47%
2011	48.0	16.9	0.36%


Нийт нөхөн төлбөр /Тэрбум төгрөг/



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ




ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ДҮН /ТЭРБУМ ТӨГРӨГ/



2016 онд "Монголын хөрөнгийн бирж" ХХК-ийн нийт арилжааны дүн 299.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 85.8 хувийг засгийн газрын үнэт цаасны арилжаа эзлэж байна. Хувьцааны арилжааны дүн 2016 оныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 49 тэрбум төгрөгт хүрсэн. Засгийн газрын үнэт цаасны 280.4 тэрбум төгрөгийн анхдагч зах зээлийн арилжаа хийгдсэн бол хоёрдагч зах зээлийн арилжаа 19.1 тэрбум төгрөгт байлаа.

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /Тэрбум төгрөг/




ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС




2016 оны байдлаар Монголын Ипотекийн корпораци 2.46 их наяд төгрөгийн орон сууцаар баталгаажсан үнэт цаас гаргаад байна. Хөтөлбөрийн хүрээнд 52535 хүн орон сууцны хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА


Банк бус санхүүгийн байгууллагын тоо




Харилцагчдын тоо /Мянгаар/



Нийт хөрөнгө /Тэрбум төгрөг/




Нийт зээл /Тэрбум төгрөг/




ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО


Хадгаламж, зээлийн хоршоодын тоо




Хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдийн тоо



/Тэрбум төгрөг/





V

АШИГТ

АЖИЛЛАГАА

АШИГТ АЖИЛЛАГАА

5.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

5.1.1 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Мэргэжлийн зуучлагч ҮЦК /брокер, дилер, андеррайтер/–иудын өнөөгийн нөхцөл байдал: Манай улсын хувьд 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт ҮЦК–иудын тоо 62 байгаа нь хөрөнгө оруулагчдын хувьд хангалттай хэмжээнд хүрсэн хэдий ч, санхүүгийн хувьд чадавхтай, үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцдог, холбогдох хууль тогтоомж болон СЗХ–ноос тогтоосон зохистой харьцааны шалгуур

үзүүлэлтийг хангаж ажилладаг компаниуд цөөн байгаа тул хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, мэргэжлийн оролцогч байгууллагуудыг чадавхжуулах замаар үнэт цаасны арилжааны хэмжээ, хөрвөх чадвар болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Хүснэгт 9: Нийт хөрөнгө /тэрбум төгрөгөөр/

Д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015 он	2016 он	Өсөлт/бууралт
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	47.5	71.6	50.6%
2	Эргэлтийн бус хөрөнгө	20.4	19.7	-3.6%
3	Нийт хөрөнгө	68.0	91.3	34.3%
4	Өр төлбөр	6.4	24.5	284.4%
5	Эздийн өмч	61.6	66.8	8.5%
6	Нийт пассив	68.0	91.3	34.3%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 оны жилийн эцсийн байдлаар нийт 62 брокер, дилерийн компаниас нэр бүхий 21 ҮЦК нь ашигтай, 35 ҮЦК нь алдагдалтай буюу тухайн хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй байдалтай байна. 2016 онд нийт компаниудын бараг тал хувь нь алдагдалтай ажилласан боловч 2015

онтой харьцуулахад алдагдлын хэмжээ буурсан буюу ашигт ажиллагаа нь нэмэгдсэн нийт 37 компани байгаа бол эсрэгээрээ өмнөх оны нөхцөл байдлаас буурсан 12 компани байна.


Д/д	Орлогын хураангуй тайлан	2015 он	2016 он
1	Үйл ажиллагааны орлого	3.6	5.5
2	Ногдол ашгийн орлого	0.04	0.05
3	Борлуулалт маркетингийн болон ерөнхий удирдлагын зардал	6.4	6.1
4	Ажиллагчдын цалингийн зардал	2.7	2.8
5	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	1.0	0.8
6	Санхүүгийн зардал	0.1	0.6
7	Бусад зардал	0.4	0.08
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-0.1	0.6
9	Бусад ашиг (алдагдал)	-0.1	-0.4
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-0.6	1.1
11	Орлогын татварын зардал	0.1	0.1
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-0.7	1.0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтерийн компаниудын тоо /давхардсан тоогоор/ 2010–2012 оны хооронд 95 болж огцом өссөн. Үүнд төрөөс “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг Монгол

Улсын иргэн бүрд үнэ төлбөргүй эзэмшүүлэх шийдвэр гаргасан нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн зуучлагчид болох брокер, дилерийн компаниудын тоо огцом өсөхөд хүргэсэн.

Зураг 40: ҮЦК-иудын тоо /брокер, дилер/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хэдийгээр үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн компанийн тоо нэмэгдсэн ч, мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулах мэргэжлийн зуучлагчид бус, харин эсрэгээр үнэт цаасны арилжаанд оролцдоггүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй, холбогдох хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүрэг, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангадаггүй компаниудын тоо нэмэгдсэн бөгөөд үүнийг дагаад хувьцааны үнэ ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах, зах зээлд худал мэдээлэл тараах зэрэг үйл ажиллагааг зарим нэр бүхий компаниуд гаргах болсон нь манай улсын хөрөнгийн зах зээлд итгэх

хөрөнгө оруулагчдын оролцоо, идэвхийг бууруулахад нөлөөлсөн.

Үүнтэй холбоотойгоор СЗХ-ны зүгээс 2013–2015 оны хооронд мэргэжлийн зуучлагч байгууллагуудын үйл ажиллагаа, санхүү, өөрийн хөрөнгө, хүний нөөцийн байдалд тавих газар дээрх болон зайны хяналт, шалгалтыг эрчимжүүлэн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага хангаагүй компаниудын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж ирсэн.

ШИГТГЭЭ 3:

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2008 оны дэлхийн санхүүгийн хямрал болон сүүлийн жилүүдэд үүсэж буй санхүү, эдийн засгийн таагүй нөхцөл байдалтай холбоотойгоор олон улсын санхүүгийн зохицуулагчид мэргэжлийн зуучлагч байгууллагуудын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, эрсдэл даах түвшнийг өсгөх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн ба мэргэжлийн зуучлагчид нь харилцагч, хөрөнгө оруулагчдын хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусад нь хадгалах, зүй бусаар ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах сан байгуулах зэрэг тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Хорооноос Дэлхийн банкны Олон салбарыг хамарсан техник туслалцааны хоёр дахь шатны төслийн хүрээнд санхүү, хүний нөөц, техник, программ хангамжийн хувьд чадавхтай мэргэжлийн зуучлагч компаниудыг бий болгох замаар төлбөрийн баталгааны санг байгуулах, өөрийн орны онцлогт нийцүүлэн төлбөр, тооцоонд DVP /төлбөрийн эсрэг нийлүүлэлт/ загварыг бүрэн нэвтрүүлэх, арилжааны дараах төлбөр тооцооны горимыг Т+2 эсхүл Т+3-д зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан шилжүүлэх, урт хугацаанд тооцооны байгууллага байгуулагдах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж, улмаар гадаадын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх болон хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг сэргээх бодлогын чиглэлийг баримтлан ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд СЗХ-ноос үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

Үнэт цаасны зах зээл дээр мэргэшсэн боловсон хүчинтэй, санхүүгийн чадавхтай, холбогдох хууль тогтоомж болон СЗХ-ноос тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангаж ажилладаг үнэт цаасны компаниуд бий болсноор төлбөрийн баталгааны сан байгуулагдах нөхцөлийг бүрдүүлж, дэд бүтцийн хөгжил болоод үнэт цаасны зах зээлийн арилжаа, хөрвөх чадварын түвшин нэмэгдэх, төлбөр, тооцооны горимыг олон улсын стандартад нийцсэн Т+2, эсхүл Т+3-д шилжих боломж бүрдэнэ.


5.1.2 ХАА-Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

2016 онд үйл ажиллагаа явуулж буй нийт 37 хөдөө аж ахуйн брокерын компаниас 9 нь тайлангаа ирүүлж, тэдгээр 9 компанийн ашигт ажиллагааны үзүүлэлтүүдийг тус бүрд нь тооцлоо. Өөрийн хөрөнгийн өгөөж болон хөрөнгө оруулалтын ашиг нь тус тус 100 хувиас дээш нэг компани, хувьцаат капиталын ашиг нь 100-аас дээш хувьтай болон хөрөнгө оруулалтын ашиг нь 91 хувьтай нэг, мөн уг үзүүлэлтүүд нь тус тус 19 болон 14 хувьтай нэг компани байна. Харин үлдсэн 7 компанийн үзүүлэлтүүд 0 хувьтай гарлаа.

5.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

2016 онд даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 дахин буюу 4.5 тэрбум төгрөгөөр өсөж, 11.4 тэрбум төгрөгт хүрэв. Өмнөх онд алдагдалтай ажиллаж байсан байгууллагуудын хувь оролцоо хамгийн өндөр байсан бөгөөд нийт даатгалын салбарын цэвэр ашгийн өсөлтийн 53.5 хувийг бүрдүүлэв. Түүнчлэн салбарын хэмжээнд хураамжийн нийт орлогын хэмжээ харьцангуй тогтвортой өсөлттэй байсан бөгөөд үндсэн үйл ажиллагааны зардал 2015 онтой харьцуулахад 24.0 орчим хувиар буурсан нь цэвэр ашгийн өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэв.

Зураг 41: Татварын дараах цэвэр ашиг



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Жич: Нэр бүхий 3 даатгалын компани 2015 оны тайланд өөрчлөлт оруулахтай холбоотойгоор татварын дараах цэвэр ашгийн дүн өөрчлөгдөв. Ердийн даатгалын компаниудын татварын дараах цэвэр ашгийн хэмжээ дунджаар 2.6 дахин өссөн бөгөөд үүнээс нэр бүхий 3 даатгалын компаниудын цэвэр ашгийн өсөлт хамгийн өндөр байв. Харин 2015 онд нэр бүхий 2 даатгалын компани алдагдалтай ажиллаж байсан бол тайлант хугацаанд ашигтай ажиллаж, ашгийн өсөлт нь нийт ердийн даатгалын байгууллагуудын 61.9 хувийг эзэллээ.


“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хувьд өмнөх онтой харьцуулахад татварын дараах цэвэр ашгийн хэмжээ 31.7 хувиар буюу абсолют дүнгээр 667.5 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарчээ.

Харин урт хугацааны даатгалын компанийн ашгийн үзүүлэлт энэ онд буурсан үзүүлэлттэй байна.

Салбарын хэмжээнд цэвэр ашгийн хэмжээ өссөн нь даатгалын салбарын цаашдын хөгжилд эергээр нөлөөлж, нийт оролцогчдын өрсөлдөх чадвар сайжрах суурь нөхцөл болж байна.

Ашигт ажиллагааны коэффициент: Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 2010 онд хамгийн өндөр буюу 22.7 хувь байсан бол 2014 онд уг үзүүлэлт буурч 3.3 хувьд хүрсэн. Гэвч тухайн үеэс өөрийн хөрөнгийн өгөөж эргэн сэргэж эхэлсэн бөгөөд тайлант хугацаанд 10.8 хувьтай байна.

Зураг 42: Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт хөрөнгийн өгөөжийн ашигт ажиллагааны үзүүлэлтэд өөрийн хөрөнгийн өгөөжтэй адил хандлага ажиглагдаж байна. 2011 онд буюу өөрийн хөрөнгийн өгөөжийн хамгийн өндөр түвшингээс 1 үе хойно нийт хөрөнгийн өгөөжийн хамгийн өндөр үе тохиож, 10.3 хувьд хүрэв. Харин 2014 онд нийт хөрөнгийн өгөөж хамгийн доод цэгтээ буюу 1.6 хувьд хүрсэн боловч ирэх онуудад нийт хөрөнгийн ашигт ажиллагаа сэргэж, энэ оны байдлаар 5.5 хувь болов.

2010–2014 онд ийнхүү хөрөнгийн өгөөж буурсан нь цэвэр ашгийн хэмжээ 3.6 дахин буурсантай холбоотой юм. Харин сүүлийн жилүүдэд нөөц сангийн тооцоолол өөрчлөгдсөнтэй холбоотойгоор даатгалын салбарын цэвэр ашгийн хэмжээ огцом өссөн нь салбарын ашигт ажиллагааны коэффициент өндөр утга авах үндэс болов.

Зураг 43: Зардлын харьцаа, хохирол нөхөлтийн харьцаа, хосолсон харьцаа



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хосолсон харьцаа: Хохирол нөхөлтийн харьцаа¹ тайлант хугацаанд 47.6 хувьтай байгаа нь өмнөх оноос 1.0 хувиар өссөн, харин зардлын харьцаа² 50.8 хувьтай байгаа нь өнгөрсөн оноос 15.3 хувиар буурсан үзүүлэлт юм.


Даатгалын салбарын хосолсон харьцаа³ 2013, 2014, 2015 онуудад харгалзан 104.9 хувь, 107.2 хувь, 111.7 хувь байсан нь тухайн жилүүдэд үйл ажиллагааны зардлыг даатгалын орлого дангаар нөхөх боломжгүй, даатгалын бус орлогоос нөхөж байсныг илтгэж байна. Тайлант хугацаанд салбарын хэмжээнд хосолсон харьцаа буюу зардлын харьцаа буурч 98.4 хувьтай гарлаа.

5.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ-ын салбарын хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж 2006 оноос тасралтгүй өсөж байсан бол 2014 оноос эхлэн зах зээлд үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой буурах хандлага ажиглагдсан.

2016 онд ББСБ-ын тоо нэмэгдэж, Санхүүгийн зохицуулах хорооноос хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлагыг нэмэгдүүлсэнтэй холбоотой нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 26.0 хувиар өссөн ба хөрөнгийн өгөөж 8.4 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.2 нэгжээр өссөн бол өөрийн хөрөнгийн өгөөж 11.8 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.5 нэгжээр буурлаа.

Зураг 44: Хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-уудын үйл ажиллагааны цар хүрээ хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс хамааран харилцан адилгүй байдаг тул ашигт ажиллагааны үзүүлэлтийг 5 ангилалд хуваан тооцоолол хийлээ.

ББСБ-уудыг хувь нийлүүлсэн хөрөнгөөр ангилсан байдал: 2016 онд 2.0 тэрбум төгрөгөөс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 41 ББСБ үйл ажиллагаа явуулсан бөгөөд салбарын нийт хөрөнгийн 44.3 хувийг, нийт орлогын 53.0 хувийг бүрдүүлж байна.

1.0 тэрбумаас 1.99 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 82 ББСБ салбарын нийт хөрөнгийн 23.3 хувийг, нийт орлогын 21.7 хувийг эзэлжээ.

800.0 саяас 999.9 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 117 ББСБ салбарын нийт хөрөнгийн 14.6 хувийг, нийт орлогын 8.6 хувийг бүрдүүлсэн.

400 саяас 799.9 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 179 ББСБ салбарын нийт хөрөнгийн 16.1 хувийг буюу 127.0 тэрбум төгрөг, нийт орлогын 12.8 хувийг буюу 24.7 тэрбум төгрөгийг эзэлж байна.

399.9 сая төгрөгөөс доош хэмжээтэй хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 99 ББСБ салбарын нийт хөрөнгийн 1.6 хувийг буюу 12.6 тэрбум төгрөг, нийт орлогын 1.4 хувийг буюу 2.8 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

1 Хохирол нөхөлтийн харьцаа=нөхөн төлбөр/орлогод тооцсон хураамж

2 Зардлын харьцаа=үйл ажиллагааны зардал/ орлогод тооцсон нийт хураамж

3 Хосолсон харьцаа=хохирол нөхөлтийн харьцаа+зардлын харьцаа

Үзүүлэлт	2.0 тэрбумаас дээш	1.0 – 1.99 тэрбум	800.0 – 999.9 сая	400 – 799.9 сая	399.9 саяас доош
ББСБ-уудын хувь	7.9%	15.8%	22.6%	34.6%	19.1%
Нийт хөрөнгийн эзлэх хувь	44.3%	23.3%	14.6%	16.1%	1.6%
Нийт орлогын эзлэх хувь	52.9%	22.7%	9.1%	13.8%	1.4%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Нийт ББСБ-ын 8 хувь нь салбарын хөрөнгийн 44 хувийг, орлогын 53 хувийг бүрдүүлж байгаа бол салбарын олонхи болох 35 хувь нь нийт хөрөнгийн 16 хувь, орлогын 14 хувийг эзэлсэн байна.

Хөрөнгийн өгөөж: Нийт хөрөнгийн өгөөжийг ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр ангилан тооцвол 0 хувиас 40 хувийн интервалд багтаж байна. Нийт ББСБ-ын

1.4 хувь нь 31 хувиас дээш хөрөнгийн өгөөжтэй ажилласан бол 8.3 хувь нь 21 хувиас 30 хувь хүртэл өгөөжтэй, 21 хувь нь 11 хувиас 20 хувь хүртэлх өгөөжтэй бол 69.3 хувь нь 10 хувиас доош хэмжээний өгөөжтэй ажилласан.

518 ББСБ-ын нийт хөрөнгийн дундаж 7 хувь, дундаж цэг болох медиан нь 4 хувь, хамгийн олон давтамж нь 0 хувь дээр тогтож байна.

Зураг 45: Нийт хөрөнгийн өгөөж /ХНХ-ийн ангиллаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Өөрийн хөрөнгийн өгөөж: Нийт ББСБ-ын өөрийн хөрөнгийн өгөөжийг тооцон 40 хүртэл хувиар интервал гарган тооцоход 1.5 хувь нь 41 хувиас дээш, 2.7 хувь нь 31 хувиас 40 хувийн, 10.2 хувь нь 21 хувиас 30 хувийн, 19.3 хувь нь 11 хувиас 20 хувийн, 66.4 хувь нь 10 хувиас доош өгөөжтэй ажиллажээ.

518 ББСБ-ын өөрийн хөрөнгийн өгөөжийн дундаж 4 хувь, дундаж цэг болох медиан 5 хувь, хамгийн олон давтамж нь 0 байна.

Зураг 46: Өөрийн хөрөнгийн өгөөж /ХНХ-ийн ангиллаар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2.0 тэрбум төгрөгөөс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-ууд өрийн санхүүжилтээр хөшүүрэгдсэнээр өөрийн хөрөнгийн өгөөж нийт хөрөнгийн өгөөжөөс өндөр гарсан

бол 800.0 төгрөгөөс доош хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-ууд өрийн санхүүжилт багатай учраас өгөөжийн түвшингүүд ойролцоо дүнтэй байна.

Зураг 47: Өгөөжийн дундаж түвшин




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дю-Понтын 3 шатлалт загвар: Уг үзүүлэлтэд нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөжийг тооцсон ба уг өгөөжид ямар хүчин зүйлс нөлөөлснийг илэрхийлэх Дю-Понтын 3 загварыг үнэлсэн болно. Үүнд, цэвэр ахиуц ашиг, нийт хөрөнгийн эргэц, нийт хөшүүргийг тооцож, 100 хувь хүртэл интервалд ангилан тооцсоныг зураг 48-д үзүүлэв.

Цэвэр ахиуц ашгийн түвшинг цэвэр ашиг болон нийт орлогын харьцаагаар, нийт хөрөнгийн эргэцийг нийт орлого болон хөрөнгийн дунджаар, нийт хөшүүргийг хөрөнгийн болон эзэмшигчдийн өмчийн дундаж харьцаагаар тооцсон болно.

Зураг 48: Ахиуц ашиг болон хөрөнгийн эргэц /ББСБ-ын тоогоор/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 онд нийт 415 ББСБ ашигтай ажилласан ба үүний 20 хувь нь нийт орлогынхоо 20 хүртэлх хувийг цэвэр ашиг хэлбэрээр, 24 хувь нь 21 хувиас 40 хувь хүртэл, 24 хувь нь 41 хувиас 60 хувь хүртэл, 16 хувь нь 60 хувиас дээш хувийн цэвэр ашгаар хөрөнгө оруулалт хийж чадсан байна. Харин 16 хувь нь ашиггүй ажиллажээ.

Тайлант онд 497 ББСБ үйл ажиллагаа явуулсан ба нийт хөрөнгөө ашиглан 48 хувь нь 20 хүртэлх хувийн орлоготой, 38 хувь нь 21 хувиас 40 хувийн, 11 хувь нь 41 хувиас 60 хувийн, 1 хувь нь 61 хувиас 70 хувийн орлого олсон.

ББСБ-уудын нийт хөшүүргийг тооцоход 91 хувь нь 100 хувиас 150 хувиар, 4 хувь нь 150 хувиас 200 хувиар, 5 хувь нь 200 хувиар өрийн санхүүжилт татан үйл ажиллагаандаа ашигласан байна.

Зураг 49: Хөшүүрэг




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

5.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-ны үр ашигт байдал: Тайлант улиралд нийт 280 ХЗХ байгаа бөгөөд үүнээс 179 ХЗХ 4.2 тэрбум төгрөгийн ашигтай, 18 ХЗХ ашиг, алдагдалгүй, 83 ХЗХ 0.4 тэрбум

төгрөгийн алдагдалтай ажиллаж салбарын хэмжээнд нийт 3.8 тэрбум төгрөгийн цэвэр ашгийг бүрдүүлжээ..

Зураг 50: ХЗХ-дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Салбарын ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.6 тэрбум төгрөгөөр буюу 18.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд ХЗХ-дын нийт орлого 24.7 тэрбум

төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.0 тэрбум төгрөгөөр өссөн. Нийт зардал 20.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.37 тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хүснэгт 12: ХЗХ-дын ашгийн хэмжээ /бүлгээр/

АШГИЙН ХЭМЖЭЭ / ИНТЕРВАЛААР/	ХЗХ-ДЫН ТОО	АШГИЙН ХЭМЖЭЭ /ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/	НИЙТ АШИГТ ЭЗЛЭХ ХУВЬ	АКТИВЫН ХЭМЖЭЭ / ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/	АКТИВЫН ӨГӨӨЖ
100 саяас дээш	8	2.5	61.1%	62.3	4.1%
50 саяас 100 сая	10	0.8	19.1%	12.2	6.5%
10 саяас 50 сая	23	0.5	11.3%	13.8	3.4%
5 саяас 10 сая	23	0.2	3.9%	3.5	4.6%
1 саяас 5 сая	67	0.2	4.2%	8.1	2.2%
1 сая хүртэл	48	0.02	0.4%	4.9	0.4%
Ашиг, алдагдалгүй	18	0.0		0.5	0.0%
Нийт дүн	197	4.2	100.0%	105.3	4.0%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Ашигтай ажилласан ХЗХ-дыг ашгийн хэмжээгээр бүлэглэн харуулбал 100 сая төгрөгөөс дээш төгрөгний ашигтай ажилласан 8 ХЗХ-дын ашгийн нийлбэр нийт

салбарын ашгийн 61.1 хувийг эзлэх бөгөөд активын өгөөж нь 4.1 хувьтай байна.



ТОГТВОРТОЙ
БАЙДАЛ


ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

6.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Зээлийн эрсдэл: ББСБ-ын салбарын зээлийн эрсдэлийн түвшинг чанаргүй зээлийн хувиар тооцоход 2016 онд 12.4 ба өмнөх оны мөн үеэс 2.6 нэгжээр өссөн. Хугацаа хэтэрсэн зээлийн хувь 5.6 хувьтай байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 0.1 нэгжээр буурчээ.

Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2006 оноос 2009 оны хооронд өсөж, 2010 оноос 2013 оны хооронд бууран, 2014 оноос эхлэн эргэн нэмэгдсэн ба 4 жилийн мөчлөгтэй байна.

Зураг 51: Хугацаа хэтэрсэн ба чанаргүй зээлийн хувь (салбараар)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээл санхүүжилт, хөрөнгө удирдлагын үйл ажиллагаа явуулдаг 464 ББСБ-аас зээлийн өрийн үлдэгдэлтэй 439 ББСБ-ыг сонгон авч хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл, зээлийн эрсдэлийн зэрэг үзүүлэлтүүдээр эрсдэлийг тооцлоо.


Нийт зээлийн үлдэгдэлтэй ББСБ-уудаас 199 буюу 45 хувь нь хугацаа хэтэрсэн, 239 буюу 54.4 хувь нь чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна.

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хувийг 5.0 хувиас 100 хувь хүртэл ангилсан болно.

Хугацаа хэтэрсэн зээл: Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй ББСБ-уудын 44 хувь нь буюу 86 нь 5 хүртэлх хувийн, 36 хувь буюу 71 нь 5 хувиас 20 хувь хүртэл, 14 хувь буюу 28 нь 21 хувиас 40 хувийн, 6 хувь буюу 12 нь 41 хувиас дээш хэмжээний хугацаа хэтэрсэн зээлтэй байна.

Чанаргүй зээл: Нийт чанаргүй зээлийн үлдэгдэлтэй ББСБ-уудын 30 хувь буюу 72 нь 5 хүртэлх хувийн, 37 хувь буюу 89 нь 5 хувиас 20 хүртэлх хувийн, 13 хувь буюу 30 нь 21 хувиас 40 хувийн, 12 хувь буюу 28 нь 41 хувиас 60 хувийн, 8 хувь буюу 20 нь 61 хувиас дээш хэмжээний чанаргүй зээлтэй болжээ.


Зураг 52: Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хувь (ББСБ тус бүрээр)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн эрсдэлийн сан: Нийт зээлд эзлэх эрсдэлийн сан болон эрсдэлийн харьцаагаар зээлийн эрсдэлээ даах чадварыг харвал зээлийн үлдэгдэлтэй ББСБ-уудын 33.9 хувь нь эрсдэлээ бүрэн даах чадваргүй байна. Нийт зээл дэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хувь болон эрсдэлийн сангийн харьцааг зураг 53-д үзүүлэв.

Зураг 53: Зээлийн эрсдэлийн сан



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ШИГТГЭЭ 4:

БАНК БА БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАР

Бичил санхүүгийн салбар нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлдэг чухал үүрэгтэй ба богино хугацааны зээл олгодог тул санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөггүй. Гэвч банк тухайн бичил санхүүгийн байгууллагын хөрөнгө оруулагч болсноор системийн хэмжээний эрсдэлд нөлөө үзүүлдэг. Учир нь банкууд банкны салбар дахь зохицуулалтын хязгаарлалтуудаас зарим хөрөнгөө чөлөөлөхөөр бичил санхүүгийн байгууллагад хөрөнгө оруулж, зээл олгодог байна. Тухайлбал, 2008 онд Марокко Улсын бичил санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн 85 хувь нь арилжааны банкны зээлийн санхүүжилтээр бүрдсэн байв. Бичил санхүүгийн салбарт системийн эрсдэлийг үүсгэж болох хоёр төрлийн эрсдэл байдаг. Үүний нэг нь бичил санхүүгийн байгууллагууд нь хадгаламж татаж, зээл олгон, цахим төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг хэдий ч банкны салбарын зохицуулалтаас ялгаатай зохицуулагддаг тул санхүүгийн системд нөлөө үзүүлдэг. Хоёр дахь нь системийн хэмжээнд нөлөө үзүүлэхүйц бичил зээлийн дахин санхүүжилт татах нь санхүүгийн системийн тогтворгүй байдалд хүргэдэг.


Эх сурвалж: CGAP

6.2 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Зээлийн үзүүлэлт: ХЗХ-дын нийт зээлийн хэмжээ энэ онд 12.1 хувиар өсөж 84.4 тэрбум төгрөг болсон бол чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1

нэгжээр буюу 5.5 хувиар өсөж, 4.6 тэрбум төгрөгт хүрлээ.


Зураг 54: ХЗХ-дын чанаргүй зээл /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн чанарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

Зураг 55: ХЗХ-дын зээлийн чанар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант улиралд нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.9 нэгжээр өсөж 5.5 хувь болсон байгаа нь салбарын хэмжээнд чанаргүй зээлийн хэмжээ зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр тогтоосон дээд хэмжээнээс хэтэрсэн байна.

Хадгаламжийн үзүүлэлт: Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 68.1 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 60 хувийг эзэлж байгаа ба үүнээс 64.9 тэрбум төгрөг буюу 95 хувь нь хугацаатай хадгаламж, 3.2 тэрбум төгрөг буюу 5 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

ҮҮНИЙГ БҮЛЭГЛЭН ХАРУУЛБАЛ:

Хүснэгт 13: ХЗХ-дын хадгаламжийн үйл ажиллагаа /тэрбум төгрөгөөр/

Д/д	Хадгаламжийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хадгаламжийн дүн	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10,000,000 дээш	1	26.4	38.7%
2	1,000,000–10,000,000	9	29.3	43.0%
3	500,000–1,000,000	4	2.4	3.5%
4	100,000–500,000	26	6.4	9.3%
5	50,000–100,000	20	1.5	2.2%
6	10,000–50,000	78	1.6	2.4%
7	5,000–10,000	60	0.4	0.6%
8	5,000 хүртэл	53	0.1	0.2%
9	Хадгаламжгүй	29	–	–
Нийт хадгаламжийн дүн		280	68.1	100.0%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 1.0 тэрбум төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 10 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 55.7 тэрбум төгрөг

байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 82 хувийг эзэлж байгаа бол хадгаламж татан төвлөрүүлээгүй 29 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 10.4 хувийг эзэлж байна.





VII

БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН
ОРЧИН

БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

7.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, оновчтой, үр дүн бүхий зохицуулалтын орчныг бий болгох зорилтын хүрээнд үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогч болон хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой СЗХ-ны нийт 6 журмыг шинээр боловсруулж, 5 журамд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

Үнэт цаасны зах зээлд санхүү, хүний нөөц, техник программ хангамжийн хувьд чадавхтай мэргэжлийн зуучлагч компаниудыг бий болгох, санхүүгийн зуучлалын чанарыг сайжруулах зорилгоор үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг эдийн засаг болоод ҮЦК-иудын үйл ажиллагааны нөхцөл байдалтай уялдуулан нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Ингэснээр олон улсын стандартад нийцсэн төлбөр, тооцооны системийг бий болгох /DVP загвар буюу төлбөрийн эсрэг нийлүүлэлт/ загварыг нэвтрүүлэх, төлбөр, тооцооны Т+2, эсхүл Т+3 горимд шилжих болон ҮЦК-иудын дундын төлбөрийн баталгааны сан байгуулагдах боломж, нөхцөл бүрдүүлэх, улмаар үнэт цаасны зах зээлийн арилжаа, хөрвөх чадварын түвшнийг нэмэгдүүлэхэд ач холбогдол бүхий алхам болсон.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан үнэт цаасны зах зээл дэх “Өөрийгөө зохицуулах байгууллага”-уудын чадавхыг сайжруулах ажлын хүрээнд өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагааны бодлогын баримт бичиг, холбогдох дүрэм болон дагалдах үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн боловсруулж, СЗХ-оор батламжлуулах үүргийг “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Монголын Үнэт цаасны арилжааны эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-д хүргүүлж улмаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн холбогдох журмуудыг СЗХ батламжилсан. Ингэснээр төрийн зохицуулагч байгууллага болон өөрийгөө зохицуулах байгууллага хоорондын чиг үүргийн давхардал арилах, төрийн зарим чиг үүрэг өөрийгөө зохицуулах байгууллагад шилжсэнээр үр дүн бүхий хяналт, зохицуулалт бий болж, мэргэжлийн оролцогч байгууллага болоод хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаа, оролцоонд эерэг нөлөөг бий болгох боломж бүрдсэн.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлд нэгдсэн биржийн тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд төрийн холбогдох байгууллага, “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Монголын үнэт цаасны бирж” ХХК, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК болон мэргэжлийн оролцогч, дэд бүтцийн байгууллагуудын хооронд 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, энэ хүрээнд эхний ээлжинд биржүүдийн арилжааны тооцоог нэгдсэн журмаар явуулах тал дээр нэгдсэн шийдэлд хүрсэн бөгөөд мэргэжлийн оролцогч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, гадаад валютын ханшийн хэлбэлзлийн эрсдэлээс хамгаалах механизмыг бүрдүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлсэн.

Хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, хөрөнгийн зах зээл дэх гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулагдах нөхцөлийг сайжруулах, улмаар бодит эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл сайжруулах үндсэн чиглэл”-д Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн нэмэлт өөрчлөлт оруулах, Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хамтын санхүүжилтийн тухай, Хөрөнгө оруулагчийг хамгаалах сангийн тухай, Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах саналыг тусгуулсан. Энэ ажлын хүрээнд бусад орны хууль эрх зүйн орчны талаарх судалгааны ажлыг эхлүүлж, дээрх хуулийн төслүүдийн танилцуулга, үзэл баримтлал, үндэслэлийг төрийн холбогдох байгууллага болон мэргэжлийн оролцогчдын төлөөллийг хамруулсан ажлын хэсгийг байгуулан хамтран ажиллах замаар боловсруулж байна.

Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх талаар тодорхой бодлогын чиглэлүүдийг тусгуулж, нарийвчилсан төлөвлөгөөний дагуу холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллалаа.

2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр “Хөрөнгийн зах зээлийн цаг”-аар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын СЗХ-нд “Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, цаашдын төлөв” сэдэвт танилцуулга, СЗХ-ны үйл ажиллагааны тайлан болон бусад бодлогын чиглэлээр авч хэрэгжүүлсэн холбогдох арга хэмжээний талаар танилцуулсан. Мөн Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг олон улсын түвшинд хүргэх, түүний эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц болон хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор Дэлхийн банкны Олон салбарыг хамарсан техник туслалцааны төслийн хүрээнд боловсруулагдсан “Capital market strategy”-стратегид үндэслэн “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг 2022 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр” дунд хугацааны хөтөлбөрийн төслийг боловсруулсан.

7.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

2016 онд даатгалын зах зээлийн хууль эрх зүйн орчныг сайжруулах, зохистой зохицуулалтыг бий болгох чиглэлээр хэд хэдэн журмуудад нэмэлт, өөрчлөлт, сайжруулалтыг хийлээ. Үүнд:

- Хорооны 2016 оны 50 дугаар тогтоолоор “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-ыг шинэчлэн батлав;
- Хорооны 48 дугаар тогтоолоор “Даатгал түүнтэй холбоотой үйл ажиллагаа, даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ыг шинэчлэн батлагдсанаар бүртгэл зөвшөөрлийн зохицуулалтын орчныг сайжрууллаа;
- Хорооны 49 дүгээр тогтоолоор журам, дансны жагсаалтыг шинэчлэсэнээр 2015 онд Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар”, “Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга” зэрэгт нийцүүлэх үүднээс даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчдоос авах зарим санхүүгийн нэмэлт тайлангийн маягтад өөрчлөлт оруулах, нэгдсэн санхүүгийн тайлангийн бүртгэлийг шинэчлэв;
- Хорооны 70 дугаар тогтоолоор “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсан;

- Хорооны 105 дугаар тогтоолоор “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журам”-ыг шинэчлэн батлав.

Мөн эдийн засаг, бизнесийн орчны нөхцөл, даатгалын компаниудын санхүү, төлбөрийн чадварын байдлыг харгалзан СЗХ-ны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 355 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлэх хугацааг 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгалаа.

Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл бүртгэлийн журам, зааварт хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэцэд 10 хувиас доош өөрчлөлт орох тохиолдолд СЗХ-нд мэдэгдэж, бүртгүүлж байхаар СЗХ-ны 407 дугаар тогтоолоор батлагдсан журамд нэмэлт өөрчлөлтийг оруулав.

Хорооны 2016 оны 235 дугаар тогтоолоор “Сайн дурын даатгалын хэлбэр”-т нэмэлт өөрчлөлт оруулснаар давхар даатгалын хэлбэрийг нэмэлтээр оруулж журмыг шинэчлэв. СЗХ-ны 2016 оны 202 дугаар тогтоолоор “Даатгал, даатгалын мэргэжлийн оролцогчийн зарим журам, зааварт өөрчлөлт оруулах” тухай тогтоолоор хэд хэдэн журмуудын зүйл, заалтад нэмэлт өөрчлөлтийг тус тус хийлээ.

Орон сууцны ипотекийн зээлдэгчийг хүртээмжтэй, оновчтой хэлбэрээр даатгалд хамруулах санал боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулав.

7.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Санхүүгийн зохицуулах хороо нь 2016 онд банк бус санхүүгийн байгууллагуудын зохицуулалттай холбоотой “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, заавар”, “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг тус тус шинэчлэн баталлаа.

ББСБ-уудын үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг хөнгөвчлөх зорилгоор СЗХ-ны 2016 оны 71 дүгээр тогтоолоор “Банк бус

санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, заавар"-ыг шинэчлэн баталсан. Энэхүү журмаар ББСБ-уудыг эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааруулан 3 ангилж, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл шаардлагуудыг нарийвчлан тодорхойлж, зохицуулалтын хэм хэмжээг тогтоосон. Тус журам батлагдсантай холбогдуулан СЗХ-ны 2008 оны 78 дугаар тогтоолоор баталсан "Итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам", 162 дугаар тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд журам боловсруулах заавар", 186 дугаар тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам", 2011 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх журам", 2012 оны 148 дугаар тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам"-ыг тус тус хүчингүй болгосон.

ББСБ-уудын эрсдэл даах чадварыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, үйлчилгээний өртгийг бууруулах, санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэх СЗХ-ны нэгдсэн бодлогын хүрээнд СЗХ-ны 2016 оны 271 дүгээр тогтоолоор Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тодорхой хугацаанд үе шаттайгаар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.

ББСБ-ын өөрийн хөрөнгө, эх үүсвэрийн зөв оновчтой бүтцийг бий болгох, эрсдэл даах чадварыг сайжруулах зорилгоор СЗХ-ны 2016 оны 147 дугаар тогтоолоор "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ыг шинэчлэн баталж, СЗХ-ны 2016 оны 269 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан. Тус журмаар ББСБ-д мөрдөх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааруулан ялгавартай тогтоож, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс зохицуулалтын байгууллагууд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг улирал бүр, итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн тайлан, зээл олголт, эргэн төлөлт, хүүгийн судалгааны тайлан, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тайлан, гадаад валют арилжааны мэдээг сар бүр тогтоосон хугацаанд СЗХ-нд ирүүлж байхаар шийдвэрлэсэн.

7.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-ны эрх зүйн үндсийг тодорхойлж, түүний үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулдаг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль 2011 онд батлагдсан. Хуульд "хадгаламж, зээлийн хоршоо" гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангасан байх бөгөөд уг хуульд зохицуулагдаж ирсэн ХЗХ-дын тоо болон гишүүдийн тоо тасралтгүй өссөөр байна. Салбарын хувьд тооны өсөлт бий болсон хэдий ч чанарын өсөлт бараг гарахгүй байгаа нь бодит байдал дээр эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийн үйл явцад тохирч ажиллахгүй байх цаашлаад салбарын зохицуулалтыг хийхэд бэрхшээл тулгарах эрсдэлтэй тул хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар хэлэлцүүлгүүдийг өрнүүлээд байна.

Монгол Улсын онцлогт уялдсан ХЗХ буюу ХАА-н салбарт тохирсон загвар бүхий бичил болон жижиг бизнес эрхлэгчдийг дэмжсэн хоршоодыг хөдөө орон нутагт нэн тэргүүнд бий болгох шаардлагатай байна.

ХЭРЭГЛЭГЧДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮЛЭЭЛТ



“Үндэсний судалгаа, зөвлөгөөний төв” ТББ-аас улирал бүр хэрэглэгчийн итгэлийн индексийн талаар судалгаа авдаг бөгөөд уг төвийн гүйцэтгэх захирал С.Алтанчимгээс ярилцлага авлаа.

Хэрэглэгчийн итгэлийн индексийн тухай танилцуулна уу? Энэхүү индексийг бусад улс оронд хэр түгээмэл үнэлдэг вэ?

Хэрэглэгчид (өрхүүд) нь ДНБ-ний хамгийн том худалдан авагч бүлэг бөгөөд Монгол Улсад ДНБ-ний 60 орчим хувийг худалдан авдаг. Хүмүүсийн хэрэглээ, хадгаламж нь тэд өөрсдийн цалин, орлогын тогтвортой байдлын талаар хэр зэрэг итгэлтэй, өөдрөг байгаагаас ихээхэн хамаардаг. Иймд эдийн засгийн байдалд энэ том худалдан авагч бүлгийн өөдрөг байдал чухал нөлөөтэй.

Эдийн засаг, санхүүгийн төлөв байдлын талаар хэрэглэгчид хэр зэрэг өөдрөг байгааг хэмждэг “Хэрэглэгчийн итгэлийн индекс” нь эдийн засгийн нэг гол үзүүлэлт бөгөөд үүнийг АНУ, Англи, Австрали, Тайланд, Украин, Хонг-Конг, Хятад, Чех, Япон зэрэг маш олон оронд тооцдог. ХИИ-ийн утга 100-аас өндөр бол хэрэглэгчид өөдрөг, харин 100-аас бага бол гутранги байгааг харуулна.

Монгол Улсад энэхүү индексийг 2009 оноос эхлэн Улаанбаатар хотын хэмжээнд жилээр тооцож байгаад


2014 оноос хойш улирал тутам улсын хэмжээнд тооцдог болсон. Хамгийн сүүлд 2016 оны 4 дүгээр улирлын ХИИ-ийг тооцоод байна. Энэ судалгаа нь ХИИ-ээс гадна хэрэглэгчдийн ойрын ирээдүйн худалдан авалтын төлөвлөгөө, инфляци, ханш, зээлийн хүү болон орон сууцны үнийн өөрчлөлтийн талаарх хүлээлт зэргийг тооцон мэдээлдэг.

Хэрэглэгчийн итгэлийн индексийн сүүлийн судалгааны үр дүн ямар гарсан бэ?

Монгол Улсын хэрэглэгчийн итгэлийн индекс 2016 оны 4 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 15.5 нэгжээр өсөж 78.4 болсон. Үүнд хүлээлтийн индексийн эрс өсөлт нөлөөлсөн. Тухайлбал, ирээдүйн хүлээлтийн индекс жилийн өмнөх түвшингээсээ 32.6 нэгжээр өсөж 115.7 болсон байна. Харин өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үед 32.7 байсан бол жилийн хугацаанд 10.3 нэгжээр (31.5%) буурч 22.3 болсон.

Өнөөгийн байдлын үнэлгээ бизнесийн нөхцөл байдал тааруухан (-35.1%) болсон болон ажлын олдоц муудсан (-26.9%) аас болж буурсан бол ойрын ирээдүйн талаарх өрхийн хүлээлт эрс сайжирсан шалтгаан нь бизнесийн нөхцөл (47.6%) болон орлого өснө (55.4%) гэсэн хүлээлттэй байгаа явдал юм.

Зураг 56: ХИИ ба ДНБ




Эх сурвалж: “Үндэсний судалгаа, зөвлөгөөний төв” ТББ

Хэрэглэгчийн итгэлийг улсын хэмжээнд л үнэлдэг үү? Эсвэл орон нутгийн түвшинд мэдээлэл гаргадаг уу?

Бид судалгааныхаа хүрээнд ХИИ-ийг бүсээр тооцон мэдээлдэг. Тухайлбал, 2016 оны 4 дүгээр улирлын

байдлаар Улаанбаатар хотод ХИИ 86.9 байхад хөдөөгийн бүсэд хэрэглэгчид илүү гутранги байна. Ялангуяа, зүүн бүсэд хэрэглэгчид хамгийн гутранги буюу ХИИ 46.9 байгаа.

Зураг 57: ХИИ /бүсээр/



Эх сурвалж: “Үндэсний судалгаа, зөвлөгөөний төв” ТББ

Танай судалгаанаас санхүүгийн зах зээлтэй холбоотой мэдээлэл гардаг уу?

2016 оны 3 дугаар улирлаас эхлэн санхүүгийн зах зээлийн талаарх олон нийтийн мэдлэг, хүлээлт ямар түвшинд байдаг талаар судалгаа авч эхэлсэн. 2016 оны 4 дүгээр улирлын судалгааны үр дүнгээс нийт судалгаанд оролцогсдын дөрөвний гурав нь арилжааны банкны үйлчилгээний талаар мэддэг бол дөрөвний гурав нь хөрөнгийн биржийн үйлчилгээний талаар мэдэхгүй гэж хариулсан. Санхүүгийн байгууллагуудын үйлчилгээний талаарх иргэдийн мэдлэгийн талаар арилжааны банк, хөрөнгийн бирж, даатгалын компани, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, хөдөө аж ахуйн биржийн үйлчилгээний талаар хэр зэрэг мэдэх вэ гэдэг асуултанд иргэдийн 69 хувь нь арилжааны банкны үйлчилгээний талаар дунд зэрэг буюу сайн мэднэ гэжээ. Харин бусад санхүүгийн байгууллагуудын хувьд иргэдийн талаас илүү нь муу буюу огт мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна. Ялангуяа хөрөнгийн биржийн үйлчилгээг дөрвөн хүн тутмын гурав нь муу буюу огт мэдэхгүй гэж хариулжээ.

Мөн манай судалгаанаас зээлийн хүүгийн өөрчлөлтийн талаарх хүлээлт, зээл авах төлөвлөгөө, мөнгөн хөрөнгөө ямар хэлбэрт хадгалах сонирхолтой байгаа зэрэг мэдээллүүд гардаг. Тухайлбал: 2016 оны 4 дүгээр улиралд хэрэглэгчдийн 20 хувь нь зээл авах төлөвлөгөөтэй байна. Мөн ирэх нэг жилийн хугацаанд зээлийн хүү өснө гэж 19 хувь, хэвэндээ байна гэж 30 хувь, буурна гэж 25 хувь нь үзэж байна.

Санхүүгийн зах зээлтэй холбоотой үр дүнг товчхон дурдвал

Давхардсан тоогоор нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 69.5 хувь нь арилжааны банкнаас зээл авах үед хүү нь чухал гэсэн бол энэ нь ББСБ-ын хувьд 38.4 хувь, ХЗХ-ны хувьд 34.4 хувь, ломбардны хувьд 29.7 хувь байна. Иргэдийн 24.6 хувь нь арилжааны банкнаас зээл авахад найдвартай байдал чухал гэсэн бол ББСБ-ын хувьд 20.1 хувь нь, ХЗХ-ны хувьд 18 хувь нь ломбардны хувьд 18.5 хувь нь найдвартай байдлыг чухалд үздэг байна.

Иргэдийн 11 хувь нь даатгалаас нөхөн төлбөр авч байсан ба ирэх хагас жилийн хугацаанд 30 орчим хувь нь даатгуулах төлөвлөгөөтэй байна. Түүнчлэн, 20 орчим хувь нь зээл авахаар төлөвлөж байгаа бөгөөд зээл авах тохиолдолд хүү, найдвартай байдал, хугацаа хамгийн чухал үзүүлэлтүүд гэж үзэж байна.

Иргэдийн 43 хувь нь хувьцаа, бондын арилжааг ашигтай гэж үздэг боловч эдгээрийн талаарх мэдлэг харилцан адилгүй байна. Санхүүгийн зах зээлд оролцогчид нь шинж чанараасаа хамааран ялгаатай мэдлэгтэй, сонголттой байгаа тул цаашид бодлого тодорхойлоход энэ мэдээллийг анхаарч үзэх нь чухал юм.

ББСБ-ЫН ХНХ-ИЙГ ТОГТООСОН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг банк бус санхүүгийн байгууллага нь хөгжиж буй орнуудад банкны үйлчилгээ хүрэхгүй байгаа орон зайг нөхөж ажилладаг. Нөгөө талаасаа банк бус санхүүгийн байгууллага нь мэдээллийн ил тод байдал, зохицуулалт бага байдгийн улмаас сүүдрийн банк хэлбэрээр ажиллаж санхүүгийн зах зээлийг системийн эрсдэлд оруулах магадлалыг нэмэгдүүлдэг.

Монгол Улсын ББСБ-ын тоо сүүлийн жилүүдэд огцом өсч байгаа нь санхүүгийн зах зээлд эрсдэл дагуулах хандлагатай байгаа тул Камбожийн Вант Улс, Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Бүгд Найрамдах Гана улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Исламын Бүгд Найрамдах Пакистан улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам улс зэрэг улсуудын бичил санхүүгийн зах зээлийн зохицуулалт, тэр дундаа ББСБ-уудын ХНХ-ийн хэмжээг хэрхэн тогтоосон талаарх туршлага судлав.

Хүснэгт 14: ХНХ-ийн олон улсын харьцуулалт

Үзүүлэлт	Камбожийн Вант Улс	Исламын Бүгд Найрамдах Пакистан улс	Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс	Бүгд Найрамдах Гана улс	Бүгд Найрамдах Социалист Вьетнам улс	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
Хүн ам	15.6 сая	189 сая	161 сая	27.4 сая	91.7 сая	1.3 тэрбум
Нэг хүнд ногдох ДНБ	1158 ам.доллар	\$1435	\$1211	\$1369	\$2111	\$1598
Нийт ББСБ тоо	54	7 (289)	32	66	1225	36347
Дүрмийн сан өсгөсөн огноо	2016–2018 он	2011–2013 он	2011–2012 он	2013 он	2011–2014 он	2014–2017 он
Өмнөх дүрмийн сан	62.5 мянган ам.доллар	500 сая рупи	500 сая така	7 сая седи	50 тэрбум дон	2.5 сая рупи
Нэмэгдсэн дүрмийн сан	1.5 сая ам.доллар	1 тэрбум рупи	1 тэрбум така	15 сая седи	500 тэрбум дон	20 сая рупи
Өсөлт	24 дахин их	2 дахин их	2 дахин их	2 дахин их	10 дахин их	8 дахин их
ХНХ-ийг нэмэх болсон шалтгаан	Санхүүгийн салбарыг бэхжүүлэх, ирээдүйд үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Компанийн засаглалыг сайжруулах	Санхүүгийн зах зээлийн эрсдэл даах чадавхийг бэхжүүлсэн	ББСБ-уудын тоо огцом өсч, зах зээлд эрсдэл өндөртэй тоглогчдын тоо нэмэгдсэн	Харилцагчдын эрх ашгийг хамгаалах, зохистой харьцааг сайжруулах	Зээлийн хэт тэлэлт, хүүгийн түвшин өндөр, ББСБ-уудын төлбөрийн чадвар муудсан

Улс орнуудын хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөсөн туршлагаас үзэхэд бичил санхүүгийн зах зээлийг бэхжүүлэх, чадавхижуулах, ирээдүйд үүсч болох болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зах зээл дэх мэргэжлийн оролцогчдыг нэмэгдүүлэх, компанийн засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэдэг байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өсгөсөн байдал нь улс орнуудын хувьд харилцан адилгүй бөгөөд 1.5–аас 12.6 сая ам.долларын интервалд багтаж байна. Камбожийн Вант Улс ББСБ-ын ХНХ-ийг хамгийн их буюу 24 дахин өсгөж, 1.5 сая ам.долларт хүргэсэн бол Исламын Бүгд Найрамдах Пакистан улс, Бүгд Найрамдах Бангладеш Ард

Улс, Бүгд Найрамдах Гана улс зэрэг орнууд 2 дахин өсгөж харгалзан 9.2 сая, 12.6 сая, 3.5 сая ам.доллар болгожээ. Түүнчлэн Камбожийн Вант Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам улс зэрэг улс орнуудад жижиг ББСБ-уудаа дэмжиж, боломж олгох үүднээс тодорхой хугацаанд үе шаттайгаар ХНХ-ийг өсгөх бодлого баримталсан байна.

Монгол Улсын бичил санхүүгийн институцийн ам.доллараар илэрхийлсэн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бусад улс орнуудынхтай харьцуулахад бага түвшинд байна.

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1: ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ /ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/

Огноо	2012	2013	2014	2015	2016
Зах зээлийн үнэлгээ	1,799.90	1,670.50	1,442.60	1,262.50	1,474.20
ЗЗҮ-ний ДНБ-д харьцуулсан хувь	10.70%	8.70%	7.00%	5.40%	6.20%
Нийт арилжаа(тэрбум төгрөгөөр): Үүнээс					
Хувьцааны арилжааны хэмжээ	144.7	97.5	24.2	30.4	49
ЗГҮЦ-ны арилжаа	0.001	1.01	36.11	515.46	299.63
Компанийн бондын арилжаа	0.31	-	-	0.502	-
Анхдагч зах зээлийн арилжаа: Үүнээс					
Хувьцаа	0.924	-	2.0659	20.112405	6.2
ЗГҮЦ	-	-	36.11	510.34	280.45
Компанийн бонд	-	-	-	0.5	-
Хоёрдогч зах зээлийн арилжаа :Үүнээс					
Хувьцаа	143.82	97.59	22.18	10.36	42.85
ЗГҮЦ	0.001	1.01	-	5.12	19.1
Компанийн бонд	0.31	-	-	0.002	-
Арилжааны хэмжээ /хөрөнгө оруулагчаар/					
Дотоодын иргэн	8.15	5.99	19.66	27.14	28.22
Дотоодын ААН	2.52	79.55	33.75	510.03	287.65
Гадаадын иргэн	2.74	2.1	3.14	5.91	6.04
Гадаадын ААН	131.65	10.97	3.82	3.33	1.82
Хөрвөх чадвар	8.04%	5.84%	1.68%	2.41%	3.33%
Топ-20 индекс	16,839.10	15,874.00	14,833.00	12,279.00	11,605.70
Бүртгэлтэй компанийн тоо	328	323	304	299	302
Брокер, дилерийн компанийн тоо	95	87	66	62	62
Үнэт цаасны данс эзэмшигчдийн тоо	766,184	775,323	785,863	804,964	886,590
Хөдөө аж ахуйн биржийн арилжаа	-	404.13	554.09	422.37	454.91

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХАВСРАЛТ 2: ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Хөрөнгө (тэрбум төгрөг)					
Нийт хөрөнгө	107.4	126.4	152.5	173.2	208.4
Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө	102.7	120.8	146.0	139.5	165.9
Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгө	4.7	5.6	6.5	7.6	7.5
Давхар даатгалын компанийн нийт хөрөнгө	-	-	-	26.1	35.0
Нийт хөрөнгийн өсөлт	32.2%	17.8%	20.7%	13.5%	20.3%
Хураамжийн орлого (тэрбум төгрөг)					
Хураамжийн нийт орлого	78.8	93.9	108.7	114.3	114.5
Ердийн даатгалын компаниудын хураамжийн нийт орлого	78.0	92.9	107.3	112.2	111.7
Урт хугацааны даатгалын компанийн хураамжийн нийт орлого	0.8	1.0	1.4	1.7	1.3
Давхар даатгалын компанийн хураамжийн нийт орлого	-	-	-	0.4	1.5
Гүнзгийрэлт	0.47%	0.49%	0.49%	0.49%	0.48%
Нөхөн төлбөр (тэрбум төгрөг)					
Нийт нөхөн төлбөр	16.9	26.5	31.5	32.9	34.29
Ердийн даатгалын компаниудын нийт нөхөн төлбөр	16.7	26.2	30.9	32.0	33.4
Урт хугацааны даатгалын компанийн нийт нөхөн төлбөр	0.2	0.3	0.6	0.9	0.89
Давхар даатгалын компанийн нийт нөхөн төлбөр	-	-	-	-	0.004
Нөөц сан (тэрбум төгрөг)					
Нөөц сан	48.8	60.4	66.1	72.8	93.0
Ердийн даатгалын компаниудын нийт нөөц сан	48.2	59.5	64.8	63.7	78.1
Урт хугацааны даатгалын компанийн нийт нөөц сан	0.6	0.9	1.3	1.5	1.5
Давхар даатгалын компанийн нийт нөөц сан	-	-	-	7.6	13.4
Давхар даатгалын хураамж (тэрбум төгрөг)					
Давхар даатгалын хураамж	20.7	26.0	31.6	42.1	37.2
Ердийн даатгалын компаниудын давхар даатгалын хураамж	20.56	25.94	31.55	41.93	37.18
Урт хугацааны даатгалын компанийн давхар даатгалын хураамж	0.04	0.06	0.05	0.02	0.02
Давхар даатгалын компанийн давхар даатгалын хураамж	-	-	-	0.19	-
Мэргэжлийн оролцогчид (тоо, ширхэг)					
Ердийн даатгал	17	16	16	15	15
Урт хугацааны даатгал	1	1	1	1	1
Давхар даатгал	-	-	-	1	1
Даатгалын төлөөлөгч	2357	3187	3260	3340	3091
Даатгалын зуучлагч	17	20	30	37	40
Хохирол үнэлэгч	9	14	20	27	31
Актуарч	18	15	15	15	15
Аудитор	43	69	84	124	126
Аудитын компани	16	22	30	40	42

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХАВСРАЛТ 3: ББСБ–УУДЫН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ /ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/

Огноо	2012	2013	2014	2015	2016
Нийт хөрөнгө	252.1	379.7	508.0	623.2	787.2
Эргэлтийн хөрөнгө	242.8	367.2	490.5	600.4	754.3
Мөнгөн хөрөнгө	66.7	113.1	156.0	174.2	243.1
Богино хугацаат хөрөнгө оруулалт	2.2	9.9	11.0	11.9	1.3
Нийт зээл	157.8	223.7	303.1	391.2	478.2
Хэвийн зээл	147.1	205.1	263.1	330.7	392.0
Хугацаа хэтэрсэн зээл	4.2	10.1	20.8	22.2	26.7
Чанаргүй зээл	6.5	8.5	19.2	38.3	59.5
Зээлийн эрсдэлийн сан	4.5	6.4	15.2	26.6	42.1
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	0.9	0.8	1.3	2.7	4.5
Эргэлтийн бус хөрөнгө	9.3	12.5	17.5	22.8	32.9
Нийт өр төлбөр	80.8	146.8	175.9	199.0	208.7
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	14.1	19.1	25.7	31.2	30.5
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	46.1	90.2	123.6	125.9	121.4
Төслийн зээлийн санхүүжилт	8.0	11.9	12.5	15.0	21.4
Эзэмшигчдийн өмч	171.3	232.9	332.1	424.2	578.5
Хоёрдогч өглөг	1.6	1.6	2.4	1.4	1.0
Хувьцаат капитал	139.2	182.3	258.2	308.5	440.5
Хуримтлагдсан ашиг	24.2	41.7	64.0	102.0	130.4
Нийт орлого	70.5	106.6	132.9	156.1	193.4
Хүүгийн орлого	45.7	66.1	89.9	119.8	135.6
Хүүгийн бус орлого	23.30	39.3	41.7	33.4	54.4
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1.10	1.1	1.3	3.0	3.5
Нийт зардал	51.9	76.8	96.5	109.7	134.4
Хүүгийн зардал	6.50	9.6	12.9	14.9	15.4
Хүүгийн бус зардал	39.50	58.8	66.7	71.3	88.9
Болзошгүй эрсдэлийн зардал	2.30	3.4	11.4	16.4	21.2
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1.00	1.2	1.0	0.9	1.9
Цэвэр ашиг	18.6	29.8	36.4	46.4	59.0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХАВСРАЛТ 4: ХЗХ–ДЫН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ /ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/

	2012	2013	2014	2015	2016
Нийт хөрөнгө	67.7	73.8	80.5	97.7	113.1
Нийт хөрөнгийн өөрчлөлт	9.4	9.0	9.1	21.3	15.8
Мөнгөн хөрөнгө	15.9	20.6	15.0	18.2	24.2
Богино хугацаат хөрөнгө оруулалт	0.0	0.0	0.0	0.0	0.02
Нийт зээл	48.3	49.4	61.5	75.3	84.4
Хэвийн зээл	46.0	46.6	57.8	69.0	74.6
Хугацаа хэтэрсэн зээл	1.3	1.2	2.1	2.9	5.2
Чанаргүй зээл	1.1	1.5	1.6	3.5	4.6
Эргэлтийн бус хөрөнгө	1.6	2.1	0.2	0.3	2.5
Өр төлбөр	51.3	54.8	60.8	76.1	88.6
Хадгаламж	47.1	50.7	55.0	59.3	68.1
Богино хугацаат зээл	1.0	0.4	0.7	1.4	3.0
Урт хугацаат өр төлбөр	0.5	0.5	1.4	11.2	12.5
Бусад богино хугацаат өр төлбөр	2.7	3.2	3.7	4.3	5.0
Өөрийн хөрөнгө	16.4	19.0	19.7	21.6	24.5
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	9.4	9.8	10.1	10.6	12.2
Хоршоологчдын өмч	6.9	8.7	9.2	10.6	12.1
Хуримтлагдсан орлого /алдагдал/	3.9	5.5	5.2	5.5	3.8
Нийт орлого	16.6	17.6	19.0	21.8	24.7
Хүүгийн орлого	15.4	16.9	18.4	21.0	23.8
Үйл ажиллагааны бусад орлого	0.7	0.3	0.3	0.3	0.4
Үйл ажиллагааны бус орлого	0.4	0.4	0.3	0.4	0.5
Нийт зарлага	12.7	13.5	15.0	18.5	20.9
Хүүгийн зардал	8.3	8.9	9.8	11.0	12.5
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	0.3	0.6	0.5	1.4	1.4
Үйл ажиллагааны зардал	3.0	3.4	4.2	5.6	6.5
Үйл ажиллагааны бус зардал	0.6	0.1	0.1	0.1	0.1
Нийт ашиг	3.8	4.1	4.0	3.2	3.8
ХЗХ–дын тоо	148.0	141.0	159.0	253.0	280.0
ХЗХ–дын тооны өсөлт	-8.6	-4.7	12.8	59.1	10.7
УБ ХЗХ–дын тоо	64.0	57.0	77.0	166.0	184.0
Орон нутаг ХЗХ–дын тоо	84.0	84.0	82.0	87.0	96.0
Гишүүдийн тоо /мянга/	26.0	27.2	30.7	39.1	46.2
Гишүүдийн тооны өсөлт	-3.3	4.8	12.7	27.5	18.0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



Цахим хуудас

www.frc.mn



Холбоо барих

51-264444



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

МЭДЭЭЛЛИЙН
СУРВАЛЖ

СТАТИСТИК МЭДЭЭЛЛҮҮД
АВАХЫГ ХҮСВЭЛ

ТУН УДАХГҮЙ



WWW.FACEBOOK.COM
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО



WWW.TWITTER.COM
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО

